



СОЁМБО



БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТӨВ ХЭВЛЭЛ

2021.01.14 №02 (10731)

Үнэ 500 төгрөг

— Дугаар эрхэлсэн дэд ахлагч Т.ИДЭР



БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ-110 ЖИЛ

Б.Баярмагнай: ОЙН ХҮРЭЭНД ИРЭЭДҮЙД ЖИШИГ БОЛОХ АЖЛУУДЫГ ӨРНҮҮЛНЭ



Энэ жил БХЯ-ны 110, Зэвсэгт хүчний 100 жилийн түүхэн ой тохиож байгаатай холбогдуулж Батлан хамгаалахын дэд сайд Б.БАЯРМАГНАЙГААС ойн хүрээнд өрнөх ажил, арга хэмжээний талаар тодрууллаа. Тэр бээр ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсгийг ахалж байгаа юм.

БХЯ-ны 110, Зэвсэгт хүчний 100 жилийн ойн хүрээнд ямар ажлууд өрнүүлэхээр төлөвлөж байгаа талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү?

-Батлан хамгаалахын

сайдны 2021 оны эхний тушаалаар БХЯ үүсэн байгуулагдсаны 110, Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг тэмдэглэх ажлын төлөвлөгөөг баталсан. Хэдийгээр төлөвлөгөө

оны эхэнд сайдын тушаалаар албажсан боловч дээрх ойнүүдийг тэмдэглэх ажлын хэсэг өнгөрсөн онд байгуулагдан ажил, арга хэмжээ эрчимтэй өрнөж эхэлсэн. Тухайлбал, ойг хэрхэн тэмдэглэх, ямар ажлууд хийх вэ гэдэг дээр харьяа байгууллагууд, эрдэмтэн судлаачид, Шинжлэх ухааны академи зэрэг олон байгууллагаас тодорхой саналууд авсан.

Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлын төлөө БХЯ-ны гүйцэтгэсэн үүрэг, яамны түүхийн талаар өнгөрсөн хугацаанд судлагдсан олон ном товхимол, бүтээл бий. Эдгээрийг зайлшгүй тодотгох шаардлагатай. Ялангуяа сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд Монгол Улсын Зэвсэгт хүчин олон улсын энхийг сахиулах ажиллагаанд маш амжилттай үүрэг гүйцэтгэж, эх орныхоо нэр хүндийг өндөрт өргөж явааг энэ ойн хүрээнд тод томруун харуулах ёстой. Монгол цэрэг өнөөдөр дэлхийн цэрэг болж чадсан. Энэ бол том амжилт. Мөн Монгол Улсын сүүлийн 100 жилийн хөгжил, дэвшил Зэвсэгт хүчинтэй салшгүй холбоотой. Энэ бүхнийг нэлээд нухацтай судалж өнөө цагийн залуучуудад ойлгуулан сурталчлах, Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдал ямар их үнэ цэнээр бидэнд олдсоныг, өвөг дээдэс маань хэрхэн яаж бидэнд өвлүүлснийг мэдүүлэх нь ойн хүрээнд зохион байгуулах арга хэмжээнүүдийн нэг амин хэсэг юм. Тийм болохоор хүүхэд, залуучуудад зориулсан олон ангит болон баримтат кино, түүхийн судалбар ном, товхимол зэрэг залуусын оюуны хэрэгцээг хангасан бүтээлүүд хийгдэнэ." (Үргэлжлэл нь II нүүрт)

(Үргэлжлэл нь II нүүрт)

ЗЭВСЭГТ ХҮЧИН-100 ЖИЛ

С.Дашзэвэг: ЗУРГААН ЧИГЛЭЛЭЭР 40 ГАРУЙ АЖИЛ ЗОХИОН БАЙГУУЛАХААР ТӨЛӨВЛӨСӨН

ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга, бригадын генерал С.ДАШЗЭВЭГЭЭС Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд ямар ажлууд төлөвлөсөн болохыг тодрууллаа.

Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд ямар ажлуудыг хийхээр төлөвлөөд байна вэ?

-Монгол Улсад Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг тэмдэглэх төлөвлөгөөнд Зэвсэгт хүчний байлдааны чадамжийг дээшлүүлэх бүтээлч ажил, эрдэм шинжилгээ, онол арга зүйн хурал, түүхт ойг угтсан тэмцээн уралдаан, урлаг соёл, сурталчилгаа гэсэн зургаан чиглэлээр 40 гаруй ажил, арга хэмжээг зохион байгуулахаар

бэлтгэлээ хангаж байна. Тодруулбал, байлдааны хөнгөн, хуягласан, тусгай зориулалтын машин бүтээх, "Монгол Улсын Зэвсэгт хүчин-100 жил" эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, "Монгол Улсын Зэвсэгт хүчин-100" гэрэл зургийн цомог, түүхэн ном бүтээх, "Эх орны цэрэг-2021" яруу найргийн наадам, Зэвсэгт хүчний "Тэргүүний ардын авьяастнуудын урлагийн нэгдсэн тоглолт", "Монгол цэрэг энхийн төлөө" дурсгалт цогцолборыг тохижуулах, Батлан хамгаалах

бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах "Нээлтэй өдөрлөг"-ийн арга хэмжээг Монгол Улсын аймаг, нийслэл, дүүргүүдэд зохион байгуулна.

Зэвсэгт хүчний анги, байгууллагууд юу хийх вэ?

-Зэвсэгт хүчний Төрлийн цэргийн командлалууд болон Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагууд ЗХЖШ-ын даргын 2020 оны 5 дугаар сард баталсан "Монгол цэргийн өдөр", "Зэвсэгт хүчний 100 жилийн ойн нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах тухай" тушаалын дагуу үйл ажиллагаагаа төлөвлөн хэрэгжүүлж байна.

(Үргэлжлэл нь II нүүрт)

"ХАРАНГА" ХАМТЛАГ ЦДБЭЧ-ТАЙ ХАМТРАН УРАН БҮТЭЭЛ ТУУРВИНА

Энэ онд Монгол Улсын анхны таван яамны нэг Батлан хамгаалах яам байгуулагдсаны 110, Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ой тохиох бөгөөд тус түүхэн ойнүүдтэй холбогдуулж Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай "Харанга" хамтлагийн уран бүтээлчид хүлээн авч уулзлаа.

Энэ үеэр Батлан хамгаалахын дэд сайд ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд тус хамтлагтай хэрхэн хамтран ажиллах тухай харилцан санал солилцов. Эх орноороо бахархах, ирээдүй болсон хүүхэд, залууст эх оронч үзэл хүмүүжил төлөвшүүлэх, эх орны үнэ цэнийг ойлгуулах, ахмад дайчдын алдар гавьяаг мөнхжүүлэх, Ардын журамт цэргээс эрин цагийн Зэвсэгт хүчний түүхийг урлагаар

дамжуулан иргэд, олон нийтэд сурталчлан таниулах үүднээс "Харанга" хамтлагийг онцолсон гэдгээ Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай хэлсэн юм.

"Харанга" хамтлагийнхан хамтран ажиллах саналыг итгэл дүүрэн хүлээн авч буйгаа онцлоод, сэтгэл зүрхээрээ дэмжихээ илэрхийлэв. Улс орноо батлан хамгаалах ариун тангарагтай тус салбарын нэгэн зууны түүхэн ойн хүрээнд олон арван ажил, арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөгдөж байгаагийн нэг нь Цэргийн дуу, бүжгийн эрдмийн чуулга, "Харанга" хамтлагийн хамтарсан уран бүтээлүүд байх болно.

Тус хамтлагийн уран бүтээлчид нь гурван жилийн цэргийн алба хаасан, бэлтгэл цолтой ахлагч нар юм.

Л.Моломжамц: ШИЛДЭГ ЦЭРГҮҮД, ТЭДНИЙГ УДИРДАХ ШИЛМЭЛ СТРАТЕГИТЭЙ БАЙСНЫГ ТҮҮХ ГЭРЧИЛНЭ



Монгол Улсад Цэргийн явдлын яам буюу өнөөгийн Батлан хамгаалах яам байгуулагдсаны 110 жилийн ой энэ онд тохиож байгаагаас гадна Монгол Улсад Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсгэн байгуулагдаад нэгэн зууны босгыг даван алхаж байна. Ардын журамт цэргээс Монгол Ардын Хувьсгалт Цэрэг, Монголын Ардын Армиас Монгол Улсын Зэвсэгт хүчин гэсэн түүхэн он тооллыг өртөөлөн хөгжсөн энэ цаг хугацаа монголчууд бидний сэтгэл зүрхэнд гүнээ нэвчин үлджээ. Үндэсний эрх чөлөөний хувьсгалаас эхлэлтэй тэдгээр түүхэн жилүүдийн дунд олон баатрууд шилээ даран төрөн гарсан ч өнөө цагт амьд сэрүүн үлдсэн нь ховор болжээ. Чухам тэдгээр баатруудын нэг Батлан хамгаалахын сайд асан, чөлөөнд байгаа дэслэгч генерал Л.Моломжамц гуайтай ярилцсанаа уншигч танд сонирхуулья. Батлан хамгаалах салбарт 70 гаруй жил зүтгэхдээ эрдэм мэдлэгийн төлөө тэмүүлж, түүнийхээ ачаар нэр хүндийн оргил, ололт амжилт бүхний манлайд гарч, бахархал дүүрэн амьдарч яваа нь өргөсөн тангарагтаа үнэнчээр зүтгэж буй жинхэнэ цэрэг эрийн жишээг тод харуулсан мэт санагдана.

(Үргэлжлэл нь IV нүүрт)

"COVID-19" УЛС ОРНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХААШАА ХӨТӨЛЖ БАЙНА ВЭ

Коронавирусийн халдвар дэлхий нийтэд тархсанаас хойш улс гүрнүүдийн харилцаа, холбоо, эдийн засаг, аялал жуулчлал, улс төр, нийгэм гээд бүхий л салбар урд өмнө нь хэзээ ч байгаагүй нөхцөл байдалтай тулгарч байна. Дэлхийн халуун цэгүүдэд өрнөж буй үйл явдлуудад ч коронавирус сайн, муу талаар нөлөөлж байгааг BBC, Reuters агентлагууд онцолсныг тоймлон хүргэж байна.

1918 онд дэгдсэн Испанийн ханиад 50 сая хүнд халдварлаж, 14 сая хүний амийг авсан юм. Тус үйл явдал нь Дэлхийн нэгдүгээр дайны нөхцөл байдалд нөлөөлж, эзэн хаант гүрнүүдийн хил хязгаарыг өөрчилж, олон улсад ажилгүйдэл, инфляцын түвшин нэмэгдсэний улмаас их хэмжээний ядуурал үүссэн. Ядуурал, ажилгүйдлийн улмаас хуучин колони орнуудад тусгаар тогтнолын хөдөлгөөнүүд эрчимжиж, иргэний дайн ихээр гарах болжээ. Нөгөөтэйгүүр тахлын улмаас улс орнууд эрүүл мэндийн судалгаа, шинжилгээгээ эрчимжүүлж, халдвар, вирус, вакцин судлалын чиглэлээр ахиц дэвшил гарав. Тэр цагаас 100 гаруй жилийн дараа 2020 оны 6 дугаар сарын эхээр "COVID-19" цар тахал 113 оронд тархаж, 363,000 гаруй хүн нас барж, Хятад, АНУ, Европт халдварын хэмжээ дээд цэгтээ хүрчээ. Африк, Ойрх Дорнод, Латин Америк, Өмнөд, Зүүн өмнөд Ази, Австралийн хүн амын дунд тархсан халдварыг тогтоон барьж чадсан ч бүрэн ангижирч чадаагүй байна.

(Үргэлжлэл нь VI нүүрт)

Б.Баярмагнай: ОЙН ХҮРЭЭНД ИРЭЭДҮЙД ЖИШИГ БОЛОХ АЖЛУУДЫГ ӨРНҮҮЛНЭ

(Түрүүч нь I нүүрт)

Үүнээс гадна ойн хүрээнд жишиг болохуйц хэд хэдэн томоохон ажлыг яамны болон Зэвсэгт хүчний удирдлага, хамт олон эхлүүлж гэж төлөвлөж байна. Батлан хамгаалах салбарын үе үеийн удирдлага, хамт олон өөрсдийн нөөц боломжид тулгуурлан ажилласаны үр дүнд салбар маань өнөөгийн түвшинд хүрсэн. Гэсэн хэдий ч сүүлийн 20, 30 жилийн хугацаанд манай салбарт томоохон хөрөнгө оруулалтын ажлууд бага хийгдсэн байна. Энэ нь улсын эдийн засгийн нөхцөл байдал болон бусад олон шалтгаантай холбоотой гэж бид үзэж байгаа. Тэгэхээр өнөөдөр хэдийгээр цар тахалтай нүүр тулж, улс орны хувьд эдийн засгийн нөхцөл байдал сайнгүй байгаа ч салбарын дотоод нөөц боломж болон гадаадын тусламж дэмжлэгийн хүрээнд Зэвсэгт хүчнийхээ нэг ангийг олон улсын жишигт нийцэхүйц хэмжээнд орчин нөхцөлийг нь сайжруулахаар зураг төслийн ажил эхэлчихсэн явж байна. Ойн хүрээнд зөвхөн нэг л ангийг жишиг болгоод зогсчихгүй, цаашид Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиуд ийм байна гэдгийг бодитоор харуулахыг зорьж байна. Мөн Батлан хамгаалах салбарын хөгжилд хувь нэмрээ оруулж, залуу халуун насаа зориулсан ахмадууд болон алба хаагчдынхаа чөлөөт цагаа өнгөрүүлэх, хөгжиж дэмжих боломжийг бүрдүүлсэн "Ахмадын болон алба хаагчдын хөгжлийн төв"-ийг барьж байгуулах ажлыг эхлүүлж байна. Батлан хамгаалах салбарын удирдлагуудын зайлшгүй анхаарч байх асуудлуудын нэг нь алба хаагчдынхаа нийгмийн асуудал, тэр тусмаа орон сууцных нь асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх явдал юм. Сайдын түвшинд бид ярилцаад салбарын алба хаагчдаа хямд өртөг бүхий орон сууцаар хангах, улмаар ипотекийн 6 хувийн зээлд хамруулах ажлыг эхлүүлэхээр төлөвлөсөн.

Өнгөрсөн хугацаанд Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд монгол цэргийн түүхийг харуулсан цогцолборыг байгуулах ажлыг Зэвсэгт хүчний Жанжин штабын хамт олон эхлүүлээд байгаа. Энэхүү ажлыг ойн хүрээндээ улам эрчимжүүлэн олон нийтийн очих дуртай орчин болгож ондоо хүлээлгэн өгөхийг зорино. Ойн хүрээнд томоохон урлаг соёл, спортын арга хэмжээнүүд болон эрдэм шинжилгээний хурал зэргээр олон нийтэд чиглэсэн ажлууд ч нэлээд төлөвлөгдсөн. Энэ мэтчилэн дурдаад байвал хийж хэрэгжүүлэхээр зорьсон олон ажил бий. Цар тахлын нөхцөл байдлаас аль болох үл хамаарч төлөвлөсөн бүхий л ажлыг бодит болгохын төлөө бид хичээнэ.

БХЯ-ны 110, Зэвсэгт хүчний 100 жил гэдэг бол түүхэн ой. Тэгэхээр салбарын төдийгүй улс орны хэмжээнд ач холбогдол өгч ажиллах нь тодорхой. Тиймээс нийгэм рүү чиглэсэн цөөнгүй ажлууд хийгдэх байх. Энэ талаар ямар ажлууд тусгасан бэ?

-Ойн хүрээнд бүх аймаг, орон нутагт нарийвчилсан төлөвлөгөөний дагуу ажил, арга хэмжээнүүд явагдана. Орчин цагийн Зэвсэгт хүчин хэрхэн хөгжиж, залуучуудын маань ур чадвар хэрхэн сайжирсныг олон нийтэд сурталчлах нь бидний хийх ёстой ажлын нэг. Жил бүр энэхүү ажлыг хийдэг. Энэ жил илүү өргөн хүрээнд хийхээр зорьж байна. Мөн агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд БОАЖЯ-тай хамтраад "Ногоон төгөл" төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Манай салбарын бүхий л нэгтгэл, анги цаашид ногоон орчинд үйл ажиллагаагаа явуулах нь чухал. Орон нутагт хэрхэн мод зүлэг тарьж, ургуулж, түүнийгээ арчлан хамгаалж болдгийг Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн үлгэрлэх нь нийгэмдээ үзүүлж буй зэрэг нөлөөлөл юм. Нэгтгэл, анги бүрийг ногоон болгох хүн хүчний нөөц боломж бидэнд хангалттай бий. Зөв зохион байгуулалт,

зөв төлөвлөлт, сэтгэл зүтгэл байхад бүрэн хэрэгжинэ гэдэгт эргэлзэхгүй байгаа.

Өнгөрсөн хугацаанд бид 2024 он хүртэл хийж, хэрэгжүүлэх ажлаа нилээд нухацтайгаар төлөвлөж, тооцож цаасан дээр буулгасан. Одоо бидэнд үлдэж байгаа богинохон хугацаанд ярихаас илүүтэйгээр нүдэнд харагдаж, гарт баригдаж, олон нийтэд мэдрэгдэх хэмжээнд бодит ажил болгох нь чухал. Тиймээс манай салбарын бүхий л хамт олон өөр өөрсдийн хариуцсан ажилдаа эзэн байж үүргээ нэр төртэй гүйцэтгэнэ гэдэгт итгэлтэй байна. Ерөнхийдөө яамны удирдлага, хамт олон ойн хүрээнд аливаа ажил хийгдээд дуусдаг биш цаашид манай салбарт жишиг болоод үргэлжлээд хэрэгждэг тийм ажлуудын эхлэлийг тавих, өнгөрсөн хугацаанд хэрэгжиж байсан арга хэмжээнүүдийг улам өргөжүүлэх бодлогыг баримталж байгаа.

Шинжлэх ухаан технологийн зөвлөл ойн хүрээнд ямар ажил хийх вэ?

-Манай салбарын цаашдын хөгжилд тэр дундаа цэргийн зориулалттай техник, технологи, зэвсэглэлийг сайжруулах, хөгжүүлэхэд эрдэмтэн, судлаач, инженерүүдийн маань идэвхтэй ажиллагаа маш чухал. Өнгөрсөн хугацаанд хийж бүтээсэн олон бүтээлтэй танилцсан. Одоо бид тэдгээр бүтээлүүдийг амьдрал, салбартаа бодитоор нэвтрүүлэхэд бодлогын болон хөрөнгө санхүүгийн хувьд дэмжиж, монгол хүн юу бүтээж чаддагийг харуулах цаг нь болсон гэж үзэж байгаа. Ойн хүрээнд манай салбарын эрдэмтэн, судлаачдын хийсэн бүтээсэн бүтээлүүд нь бодитоор олон нийтийн хүртээл болох боломжийг бүрдүүлэхэд Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн ажил чиглэгдэх болно.

Ахмад Д.МЭНДБАЯР

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙХЭН САЙН ҮЙЛСИЙН АЯНД

Монгол оронд "Covid-19" цар тахлын дэгдэлт ихсэн улс орны эдийн засгийн чадавч багасаж буй энэ цаг үед зарим нэгтгэл, анги, салбар, ЗДТГ-ын Цэргийн штабууд ард иргэдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж байна.



➤ Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийнхны хувьд өнгөрсөн 2020 он төмөр замын бүтээн байгуулалтад гар бие оролцохын зэрэгцээ хүн нэг бүрийн бэлтгэл, бэлэн байдал, сургалт бэлтгэлд анхаарч ажилласан бүтээлч жил байсан юм. Харин энэ удаа орон даяар бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан тус ангийн захирагч, хурандаа Ш.Батдаваа хамт олноо төлөөлөн гал тогооны бэлтгэгч Д.Дашдаваад нийгмийн хамгааллыг нь дэмжих хүрээнд өргөө цагаан гэрийг газрын гэрчилгээний хамт гардуулжээ.



➤ Зэвсэгт хүчний 331 дүгээр ангийн эмэгтэйчүүдийн зөвлөл сайн үйлсийн аяныг зохион байгуулж Баян-Өлгий аймгийн Өлгий хотын оршин суугч гурав, Сагсай сумын долоон өрхөд гурил, будааны тусламж үзүүлэн хүүхдүүдэд нь бэлэг гардуулжээ.



➤ Хүйтний эрч чангарч буй энэ цаг үед аймаг, дүүргүүдийн ЗДТГ-ын Цэргийн штабуудаас хугацаат цэргийн алба хаагчдын ар гэрийн нийгмийн асуудалд анхаарал хандуулан, хандив тусламжийг цаг ямагт үзүүлсээр байгаа билээ. Харин энэ удаа Баянзүрх дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, дэд хурандаа Т.Амартогтох тэргүүтэй албаныхан тус дүүргээс 2020 оны II ээлжээр цэргийн албанд татагдсан дөрвөн хугацаат цэргийн алба хаагчийн хүүхдүүдэд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазарын гарын бэлгийг гардуулан, ар гэрийхэнтэй нь холбоонд оруулсан бол Говь-Алтай аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын хамт олон хугацаат цэргийн алба хааж буй 10 цэргийн алба хаагчдын ар гэрт 1.000.000 төгрөгийн хүнсний тусламжийг үзүүллээ.



➤ Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн залуу эмэгтэй офицерууд нэгдэж, Өмнөговь аймгийн Даланзадгад сумын алслагдсан гэр хороололд амьдардаг, амьдралын түвшин доогуур болон олон хүүхэдтэй айл өрхийг сонгон бяцхан үрсэд нь сэтгэлийн бэлэг тараах хандивын аяныг өрнүүллээ. Мөн Өмнөговь аймгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд ХБНГУ-ын Элчин сайдын яамнаас "КОВИД-19" цар тахалтай холбоотойгоор хөл хорионы энэ үед зорилтот бүлгийн олон хүүхэдтэй гэр бүлд дэмжлэг үзүүлэх, тэдний хэрэгцээг хангах зорилгоор таван өрхөд 100,000 төгрөгийн үнийн дүн бүхий ваучер олголоо. Иргэд хүнс болон ахуйн хэрэгцээний бараа бүтээгдэхүүнийг өөрсдөө сонгож, "Номинговь" супермаркетаар үйлчлүүлж худалдан авалт хийх боломжтой юм.



➤ Зэвсэгт хүчний 340 дүгээр ангийн удирдлага, хамт олны санаачилгаар онцгой нөхцөлд албан үүргээ гүйцэтгэж буй Баян-Өлгий аймгийн тусгайлан чиг үүрэг бүхий байгууллагуудын алба хаагчдад тус ангийн цэргийн гал тогооны ээлжийн бүрэлдэхүүн нарийн боов, жигнэмэг, халуун аарцаар үйлчлэн нийгмийн хариуцлагын хүрээнд сэтгэлийн дэмжлэг үзүүллээ.

С.Дашзэвэг: ЗУРГААН ЧИГЛЭЛЭЭР 40 ГАРУЙ АЖИЛ ЗОХИОН БАЙГУУЛНА

(Түрүүч нь I нүүрт)

Энэ дотроо Зэвсэгт хүчний 100 жилийн ойг угтсан бүтээлч ажлын төлөвлөгөө гаргаж, хамт олны дунд бүтээлч ажлын аян, уралдааныг зарлан, үйл ажиллагаагаа эрчимжүүлээ.

Мөн Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын удирдах бүрэлдэхүүний дунд спортын цогцолбор тэмцээн, "Зэвсэгт хүчний Хуурай замын цэрэг 100 жил", "Агаарын цэргийн хөгжлийн стратегийн зорилт-үзэл баримтлал" сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулна. Төр, цэргийн нэрт зүтгэлтэн, хурандаа генерал Ж.Ёндон агсны дурсгалын цогцолборыг Сүхбаатар аймгийн Баруун-Урт хотод, "Монгол ард" нисэх эскадрилийн дурсгалын цогцолборыг Зэвсэгт хүчний 337 дугаар ангид, Дурсгалын хөшөөт цогцолбор, ногоон төглийг Хуурай замын цэргийн командлалын байрлалд тус тус байгуулж тохижуулна. Баярын өдөр буюу 3 дугаар сарын 18-нд жанжин Д.Сүхбаатарын талбайд цэргийн нэгдсэн тооллого, ёслолын буудлага, шагнал гардуулах ёслолын ажиллагааг зохион байгуулна.

Зэвсэгт хүчний үйл ажиллагааг иргэд, хүүхэд залууст сурталчлах нь гол ажлуудын нэг байх нь тодорхой. Энэ чиглэлээр ямар ажил зохион байгуулах вэ?

-Зэвсэгт хүчний үйл ажиллагааг иргэд, хүүхэд, залууст сурталчлах чиглэлээр "Монгол Улсын Зэвсэгт хүчин-100" сэдэвт гар зургийн уралдааныг нийслэл, аймаг, сум, дүүргийн ЕБС-ийн бага, дунд, ахлах ангийн сурагчид болон их, дээд сургууль, коллежийн оюутнуудын дунд 1 дүгээр сарын 20-ноос 3 дугаар сарын нэгний хооронд зохион байгуулж, шилдэг 50 бүтээлээр үзэсгэлэн гаргана.

ЗХЖШ-ын хэвлэл мэдээллийн алба, Монгол цэргийн музей, Батлан хамгаалахын Төв архив хамтран Зэвсэгт хүчний 100 жилийн ойд зориулсан дижитал үзэсгэлэн гаргаж иргэд,



хүүхэд, залуучуудын оюуны хүртээл болгох юм. Зэвсэгт хүчний нэгтгэл, ангидын офицер, ахлагчид нийслэл, орон нутгийн ЕБС-ийн болон их, дээд сургууль, коллежийн оюутнуудад "Монгол цэрэг-Бүтээн байгуулалтад", "Монгол цэрэг-Энхийг дэмжих ажиллагаанд", "Монгол Улсын Зэвсэгт хүчин-100 жил" зэрэг сэдвээр цуврал лекц, сургалт сурталчилгааны ажлыг тус тус зохион байгуулна.

Хүүхэд, залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд БХЯ, нийслэл, орон нутгийн Цэргийн штабуудтай хамтран ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд зохиогддог цэрэгжлийн спортын "Дөл" цогцолбор тэмцээнийг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж байна.

Б.Амгаланбаатар: ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГУУЛЖ, САХИЛГА, ХАРИУЦЛАГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ ЧУХАЛ

Зэвсэгт хүчний
Хуурай замын цэргийн
командлагч, бригадын генерал
Б.АМГАЛАНБААТАР:

2021 онд Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлал ямар зорилго, зорилтыг дэвшүүлсэн бэ?

-Энэ түүхэн жилд бид маш завгүй хөдөлмөрлөж, тодорхой амжилтуудыг гаргасан байх учиртай. Ялангуяа, цэргийн сургалт бэлтгэлт, бэлэн байдал, бие бүрэлдэхүүний бие бялдар, эрүүл мэнд, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, цэргийн алба хаагчдаа олон нийтэд сурталчлах гээд их ажил биднийг хүлээж байна. Өнгөрөгч 2020 он улс орны батлан хамгаалах чадавхыг бэхжүүлэх, Зэвсэгт хүчний шинэчлэлийг эрчимжүүлэх, хууль, эрх зүйн орчноо төгөлдөржүүлэх, бүтээн байгуулах зэрэг олон амжилт дагуулсан жил байлаа. Хуурай замын цэрэг нь цаг үеийн шаардлагаар дэвшигдэн гарч байгаа олон чухал зорилтуудыг хангах, мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчний төлөвшүүлэх, цэргийн захиргааны удирдлагыг хангах, Зэвсэгт хүчний хуулиар хүлээсэн үүрэг гүйцэтгэх бэлэн байдал, чадавхыг нэмэгдүүлэх зэрэг зорилтуудыг шийдвэрлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлсэн он жил байлаа.

Хэдийгээр цар тахлын улмаас шалтгаалан амаргүй нөхцөл байдалд үйл ажиллагаагаа явуулсан хэдий ч ЗХЖШ-аас зохион байгуулсан "Штабын бэлтгэлээр тэргүүлэгч анги" шалгаруулах үзлэгт нэгтгэл, ангиуд амжилттай шалгуулан, Монгол Улс, ОХУ-ын хамтарсан байлдааны буудлагатай "Сэлэнгэ" тактикийн хэргийн сургуулийг анх удаа улс бүр өөр өөрийн нутагт, команд штабын сургуулийг ОХУ-ын нутагт хамтран зохион байгуулж, Хуурай замын цэргийн гадаад харилцааг өргөжүүлэх үүднээс дэлхийн хэд хэдэн орны ижил чиг үүргийн байгууллагатай цахимаар харилцаж хамтын ажиллагааныхаа чиглэлүүдээ тодорхойлж тодотголоо. Хуурай замын цэргийн бие бүрэлдэхүүний алба хаах ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилготой олон арван бүтээн байгуулалтын ажил нэгтгэл, ангиудад хэрэгжиж амжилт бүтээл арвин байлаа. 2021 онд Хуурай замын цэргийн хэмжээнд Цэргийн захиргааны удирдлагыг тасралтгүй хэрэгжүүлж, Хуурай замын цэргийн үүрэг гүйцэтгэх чадавх, бэлэн байдлыг хангах үндсэн зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна.

Онцлог ажил, арга хэмжээний тухайд...

-Хуурай замын цэргийн удирдлага, төлөвлөлтийн баримт бичгүүдийг боловсруулж, хэрэгжүүлэх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, нэгтгэл, ангиудын бэлэн байдлыг дээшлүүлэх, үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлж, харилцан ажиллагааг бэхжүүлэх, цэргийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг ханган цэргийн алба, сахилга, дэг журмыг бэхжүүлэх, цэргийн хотхоны стандартын дагуу нэгтгэл, ангиудыг бүсчилэн хөгжүүлэх гээд нэрлэж болно. Тэр дундаас онцлон дурдвал АНУ-ын Энэтхэг, Номхон далайн Хуурай замын цэргийн командлалтай хамтарсан сургалт, дадлага, "Сургалтын төв" төслийг ирэх 3 дугаар сараас хэрэгжүүлэхээр төлөвлөвд байна. Он гарснаас хойш баримт бичгийг боловсруулж болгох ажил нэлээд эрчтэй явагдаж байна.

Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд



зохион байгуулахаар төлөвлөсөн ажлуудынхаа талаар мэдээлэл өгнө үү?

-ЗХЖШ-аас баталсан "Монгол цэргийн өдөр", Зэвсэгт хүчний 100 жилийн ойг тохиолдуулан хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг үндэслэн Хуурай замын цэргийн командлал, нэгтгэл ангиудын төлөвлөгөө гарч, эхнээсээ цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан хэрэгжүүлж эхлээд байна. "Зэвсэгт хүчний Хуурай замын цэрэг-100 жил" эрдэм шинжилгээ, онолын бага хурал, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагчийн нэрэмжит "Тактикийн олимпиад"-ыг зохион байгуулж, "Зэвсэгт хүчний Хуурай замын цэрэг" гэрэл зургийн цомог, "Артиллерийн цэрэг-100 жил" ном, гэрэл зургийн цомог бүтээх, зарим зэвсэглэл, техникийг сэргээн сайжруулах төслийг тус тус хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Цар тахлын нөхцөл даамжрах төлөвтэй байна гэж мэргэжлийн байгууллагууд дүгнэж байгаа энэ үед сургалт бэлтгэл болон цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлыг хэрхэн зохион байгуулах вэ?

-Энэ үеийг хэрхэн амаргүй бөгөөд сахилга, хариуцлагыг бүх түвшиндээ шаардсан цаг хугацаа. Цар тахлаас урьдчилан сэргийлэх бүх ажил, арга хэмжээг Хуурай замын цэргийн хүрээнд хэрэгжүүлж байна. Улсын онцгой комисс, ЭМЯ болон БХЯ, ЗХЖШ, ХЗЦК-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх заавар, зөвлөмжийг нэгтгэл, ангиуддаа хүргүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна. Нэгтгэл, ангиудын бэлэн байдал, цэргийн алба, сургалт бэлтгэлийг цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан тасралтгүй явуулах талаар ч анхаарч байна. Цар тахлын энэ үед цахимыг ашиглахад ахиц гарч, хэрэглэж хэвшээд сурчихлаа. Хугацаат цэргийн алба хаагчдын сургалтыг төлөвлөгөөний дагуу явуулж, нэгтгэл, ангиудын байнгын бүрэлдэхүүний сургалтыг цахимаар зохион байгуулж байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх талаар хэрхэн ажиллах вэ?

-Бидний хувьд нэгтгэл, ангиуддаа өдрийн талх шигээ сануулж, үүрэгддэг асуудал л даа. Энэ онд Хуурай замын цэргийн хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулж, сахилга, хариуцлагыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч ажиллана. Батлан хамгаалахын сайд, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга ч аюулгүй байдал, сахилга, хариуцлагатай холбоотой асуудал гаргахгүй байхыг үүрэг болгож байгаа.

О.ЭНХБАЯР: ЦАР ТАХЛЫН ҮЕД ТӨЛӨВЛӨСӨН АЖЛУУДЫГ ЯВУУЛАХ ОЛОН АРГА ЗАМ БИЙ

Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч, бригадын генерал О.ЭНХБАЯР:

Танай командлал 2021 онд ямар зорилго, зорилтууд дэвшүүлсэн бэ? Цар тахалтай холбоотойгоор дээрх зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд онцлог хэлбэрээр явагдах ажлууд бий юу?

-Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал 2021 онд эрх зүйн болон удирдлага, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийг зохион байгуулж, техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэн Агаарын цэргийн үүрэг гүйцэтгэх чадавх, бэлэн байдлыг хангах зорилгыг дэвшүүлсэн. Энэхүү зорилгыг хэрэгжүүлэхийн тулд эрх зүйн орчин, удирдлага, төлөвлөлтийн баримт бичгийн бүрдэл, нийцэл, хэрэгжилтийг хангаж, Агаарын цэргийн үйл ажиллагааны бие даасан байдлыг бэхжүүлэх, штабын болон мэргэжлийн бэлтгэл сургалтад чанарын ахиц гарган, мэргэшсэн чадварлаг мэргэжилтнийг бэлтгэх, технологийн дэвшил, инновацыг нэвтрүүлэх зэрэг олон зорилтыг өмнөө тавиад байна. Цар тахлын улмаас зарим нэг ажлын хэрэгжилтэд хүндрэл үүсэхийг гүйцсгэхгүй. Гэхдээ хэрэгжүүлэхгүй гэсэн үг биш. Үүнийг шийдвэрлэх олон боломж байгааг өнгөрсөн онд Зэвсэгт хүчний нийт бүрэлдэхүүн туршиж үзсэн бөгөөд шууд харилцаанд оролгүй зайнаас цахим хэлбэрээр явуулах зэрэг олон арга байна.

Ойн үеэр Агаарын цэргийн командлал, харьяа ангиуд ямар ажлуудыг төлөвлөсөн бэ?

-Батлан хамгаалахын яамны 110 жил, Зэвсэгт хүчний 100 жилийн ойд зориулсан нэгдсэн төлөвлөгөөг Зэвсэгт хүчний Жанжин штабаас гаргасан. Энэхүү төлөвлөгөөнд Агаарын цэргийн командлалаас хийх ажлуудыг тодорхой тусгаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Зэвсэгт хүчний түүхэнд Агаарын цэргийн байр суурь том үсгээр бичигддэг. Дэлхийн хоёрдугаар дайны үед Монгол Ардын Арми Нисэх дивизтэй байсан. Тиймээс Агаарын цэргийн түүхэн замнал, алдар гавьяаг хүүхэд, залуучуудад таниулах, сурталчлах үүднээс зэвсэглэл, техникээ дэлгэнэ. Мөн Зэвсэгт хүчний Агаарын цэрэг гэж ямар үйл ажиллагаа явуулдаг, байлдааны жижүүрлэлт гэж юу болох, агаарын орон зайн хяналт зэрэг мэдээллийг иргэдэд хүргэхийг зорин.

Өнгөрсөн онд Батлан хамгаалахын сайд Агаарын цэргийн командлалд ажиллах үеэрээ техник, хэрэгслийн шинэчлэлтэй холбоотой асуудлуудыг дэвшүүлсэн. Эдгээр ажлын хэрэгжилт ямар шатандаа явж байна вэ?

-Агаарын цэргийн дийлэнх зэвсэглэл, техник нь ЗХУ-ын Зэвсэгт хүчинд ашиглаж байсан хуучин зэвсэглэл, техник байгаа нь нууц биш. Ийм байдалтай цаашаагаа үйл ажиллагаагаа явуулахад хүндрэлтэй байгааг Батлан хамгаалах болон Зэвсэгт хүчний удирдлага ойлгож, зэвсэг, техник хэрэгсэл шинэчлэх ажлыг бүх талаар дэмжин ажиллаж байна. Агаарын цэргийн зэвсэглэл, техник хэрэгсэл нь орчин үеийн нарийн технологи бүхий өндөр өртөгтэй хэрэгсэлүүд байдаг тул нэг дор бүгдийг нь шийдэх боломжгүй. Тиймээс тодорхой төлөвлөгөө гарган үе шаттай шинэчлэх ажил явагдаж байна. Бидний хувьд өөрсдийн нөөц, боломжид тулгуурлан зарим техник хэрэгслийн шинэчлэх төсөл, хөтөлбөрийг боловсруулан Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын зөвлөл болон Батлан хамгаалахын сайдын зөвлөлд танилцуулсан. Уг төсөл, хөтөлбөрийн тодорхой хэсгүүдийг энэ жил Зэвсэгт хүчний Хөгжлийн сангийн хөрөнгөөр шийдвэрлэнэ.



Онцолбол, Агаарын цагийн байдлын мэдээг боловсруулах автоматжуулалт, радиолокацийн станцуудыг тоон системд шилжүүлэх асуудал, холбоо, удирдлагын системийг орчин үеийн шаардлагад нийцүүлэх зэрэг ажлыг дурдаж болно. Нэг үеэ бодоход Агаарын цэргийн боловсон хүчний чадвар, чадавх нэлээн сайжирсан. Тиймээс зарим техник хэрэгслийг агаарын цэргийн алба хаагчид өөрсдөө зохион бүтээх, туршиж ажлууд давхар явагдаж байна.

Алслагдсан анги, салбарт ажиллаж байгаа цэргийн алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар төлөвлөсөн ямар ажлууд байна вэ?

-Алслагдсан анги, салбарт ажиллаж байгаа офицер, ахлагчид алба хааж байгаа нөхцөлөөсөө шалтгаалж төв суурин газар ажиллаж буй цэргийн алба хаагчдаас илүү олон нэмэгдэл авдаг. Гэхдээ олон нэмэгдэл авдаг гээд хайхрахгүй орхилгүй жил бүр нийгмийн асуудлыг сайжруулах ажлуудыг хийсээр ирсэн. Энэ жилийн хувьд байлдааны жижүүрлэлтэд гардаг бие бүрэлдэхүүнд нэмэгдлийг нь олгох асуудлыг Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын зөвлөлийн хурлаар оруулан тодорхой чиглэлүүдийг гаргасан. Одоо Батлан хамгаалахын сайдын зөвлөлөөр хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. Дээр хэлсэнчлэн агаарын цэргийн боловсон хүчин гадаадын их, дээд сургуульд суралцаж төгссөн залуусаар эгнээгээ өдөр ирэх тусам өргөтгөж байна. Эдгээр залуус нь Монгол Улсын аль ч цэгт буюу алслагдсан анги, салбарт ажиллахад бэлэн байгаа нь маш сайшаалтай. Харин тэднийг томилодоод очиход амьдрах орон сууцны асуудал шийдэгддэг. Энэхүү нийгмийн асуудлыг хийдвэрлүүлэх ажлын хүрээнд 2021 онд хоёр ч салбарт албан тушаалын орон сууц барихаар төлөвлөж байна. Мөн орон нутгийн өмчит объектуудыг шилжүүлэн авч, засаж сайжруулан цэргийн алба хаагчдаа оруулах асуудлууд ч яригдаж байгаа.

Сүүлийн жилүүдэд явагдаагүй хэд хэдэн команд-штабын сургуулийг Агаарын цэргийн ангиудын дунд явуулсан. Энэ жил уг сургуулийг ямар хэлбэрээр явуулах вэ?

-Хуурай хүлээсэн үндсэн үүрэг болон бусад үүргийг хэрэгжүүлэхийн тулд сургалт бэлтгэлийг тогтмол явуулна. Цэргийн сургалт бэлтгэлийн хамгийн үр дүнтэй хэлбэр нь команд штабын болон тактикийн хэргийн сургуулиуд байдаг. Тиймээс өнгөрсөн жил явагдсан нэгдсэн команд штабын сургууль, тактикийн хэргийн сургуулиудыг 2021 онд улам чанаржуулж явуулна. Дээр хэлсэнчлэн, өөрсдийн нөөц бололцооны хүрээнд хийж, хэрэгжүүлж байгаа техник хэрэгслийн шинэчлэлийг тус сургуулиудаар туршиж үздэгээрээ давуу талтай юм.

Ц.Энхманлай: БИД ЭНЭ САЛБАРЫН "БҮТЭЭГДЭХҮҮН", ТУШААЛ АВСАН "ЦЭРЭГ"-ҮҮД ШҮҮ ДЭЭ

"Харанга" хамтлагийн ахлагч Монгол Улсын төрийн шагналт, гавьяат жүжигчин Ц.ЭНХМАНЛАЙ

БХЯ-ны 110, Зэвсэгт хүчний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхэд "Харанга" хамтлагийн уран бүтээлчид хувь нэмрээ оруулах үүрэг хүлээлээ шүү дээ. Сэтгэгдлээсээ хуваалцана уу?

-Иргэнийхээ, эцэг хүнийхээ хувьд бидэнд санаа зовж, сэтгэл эмзэглэж явдаг зүйл их байна. Юунд гээч, өнөөгийн залуусын дийлэнх нь бие бялдар, сэтгэл зүйн хувьд маш нялцгай байгаад, үндсэрхэг үзэл, эх оронч сэтгэлгээ дулимаг байгаад, хүнээс үг дуулах чадвар, аливааг хүндрэл бэрхшээлийг даван туулах тэвчээр хатуужил маруухан байгаад, Тийм учраас түүхэн ойн хүрээнд БХЯ, ЗХЖШ-тай хамтран ажиллах саналыг маш сэтгэл хангалуунаар, баяртайгаар хүлээн авч байна. Бидэнд татгалзах эрх байхгүй, нэг талаасаа энэ бол бидний үүрэг. Бид чинь энэ салбарын "бүтээгдэхүүн", тушаал авсан "цэрэг"-үүд. Өөрсдийнхөө чадах чинээгээр, сэтгэл зүрхээрээ дэмжиж ЦДБЭЧ-тайгаа хамтран ажиллахад бэлэн байна.

Энэ салбарын "бүтээгдэхүүн"-ий хувьд Та Батлан хамгаалах, Зэвсэгт хүчнийхээ талаар юу ярих вэ?

-Батлан хамгаалах, Зэвсэгт хүчин гэдэг бол улс үндэстний оршин тогтнолыг хамгаалж байдаг хамгийн том хүчин зүйл. Тэр утгаараа армид алба хаасан, армиар хүмүүжсэн хүмүүс эх оронч үзэлтэй, шударга, тэвчээр, хатуужилтай болж төлөвшдөг. Ингээд бодохоор Арми бол нийгмийг манлайлж, зөв зүлт чиглүүлж явдаг гэж би үздэг юм. Манай хамтлагийнхан бүгд цэргийн



алба хаасан. ҮЖҮНХ-д хамгийн бага нь би байна уу даа, зургаан жил, зарим нь бүр 18 жил алба хаасан, бэлтгэл ахлагч нар шүү дээ. Бидний өдий зэрэгтэй явах үндэс суурийг тавьсан гол тулгуур нь Зэвсэгт хүчин, түүнээс олсон хүмүүжил. Олон хүн биднээс нэг ч гишүүнээ хасалгүйгээр 30 жил оршин тогтносон нууц чинь юу вэ гэж асуудаг. Энэ ердөө л армийн хүмүүжил. Буруугаа хүлээх, хариуцлагатай байх, цаг барих гэх мэт бүх талаар манайхан алдаа гаргадаггүй. Энэ чинь нөгөө л армиас олсон суурь хүмүүжил. Бидэнд бас маргаа зүйл байна, дандаа инээгээд тэврэлдээд явж байна гэж юу байх вэ дээ. Энэ бүхнийг армиас

олсон хүмүүжил, ёс зүйгээр шийддэг.

"Харанга"-ын уран бүтээлүүдэд эх орны сэдэвтэй нь нэлээд жин дардаг. Энэ бас л Та бүхний зүрх сэтгэл Батлан хамгаалах, Зэвсэгт хүчинтэй ямагт уятай байдгийг илтгэх мэт...

-Тэгэлгүй яах вэ. Нэгдүгээрт урлаг өөрөө хатуу шүүлтүүртэй. Тэр дунд бид зүгээр нэг санаанд орж ирсэн шүлгээрээ, санаанд орж ирсэн аялгуугаараа уран бүтээл хийх сонин биш. Хүнд юу хүргэж, юу ойлгуулах вэ гэдэг дээр толгойгоо ажиллуулна. Тиймдээ ч эх орноо хайрлаач, үнэ цэнийг нь мэдрээч, бие биеэ хүндлээч, газар шороогоо хамгаалаач гэдгийг уран бүтээлээрээ дамжуулан илэрхийлж байгаа юм. Нэг ёсондоо ухуулах маягийн юм хийгээд байна аа даа. Үүний нөгөө талд бас бидний армис олж авсан эх оронч сэтгэлгээ, үндсэрхэг үзэл оршиж байгаа юм.

Байлдагч ахуй үеийнхээ дурсамжаас сөхвөл та юуг онцлох вэ, тэр үед хугацаат цэргийн алба хэр байсан бэ?

-Би гурван жилийн байлдагч, 1978 онд тухайн үеийн Ардын Армийн 122 дугаар ангид "бүл нэмж" байв. Миний амьдралын хамгийн гэгээн дурсамжууд тэр цаг хугацаатай салшгүй холбоотой. Бидний үед цэргийн эрдмийг арай түлхүү үздэг, цэрэг гэж хэн болох, цаашлаад хүн байхад жинхэнэ сургаж "шахдаг" байлаа. Тэглээ гээд гошигнож гулгаанаад, оргож зугтаад байдаг

байлдагч байгаагүй дээ. Ганц хоёр этгээд оргох оролдлого хийдэг л байсан. Гэвч бүх л аавын хүүхдүүд албаа нэр төртэй хаагаад, эр хүн болж төлөвшөөд халагддаг байв.

Тухайн цаг хугацаагаар аялуулдаг зүйлс танд бий юу?

-Надад миний байлдагч байх үеийн гэрэл зураг олон бий. Тэр бүхнээс би маш их эрч хүчийг авдаг бас амталдаг. Шинэхэн байлдагч яаж шантарч явснаа, түүнийгээ даван туулсан хал цэрэг ямар их бардам байснаа олж хардаг. Үүнээс гадна надад тоглолтын нэг цэнхэр китель бий. Омголон залуу насаа, омог бардам уран бүтээлүүдийнхээ охь шимийг тэр кителисээ мэдэрдэг юм.

Ярилцлагынхаа төгсгөлийг танд үлдээ...

-Хүн бүр зорьж тэмүүлсэн мөрөөдөлтэй. Түүндээ хүрэхийн тулд маш их хүндрэл бэрхшээл, саад нугачааг туулдаг. Тэр бүхнийг даван туулахад цэргийн албанаас олж авах бяр чадал, тэсвэр, хатуужил танд их туслана гэдгийг л залууст хандаж хэлмээр байна. Дээр нь энэ салбарынхаа түүхэн ойнуудын үеэр төдийгүй цаашид ч үргэлж хамтын ажиллагаатай байж, эх орны ирээдүй болсон хүүхэд, залуусаа эх оронч сэтгэлтэй иргэн болгож төлөвшүүлэхэд бүхий л сэтгэл зүрхээ зориулна.

Ахмад Д.МЭНДБАЯР



БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ-110 ЖИЛ

Л.Моломжамц: ШИЛДЭГ ЦЭРГҮҮД, ТЭДНИЙГ УДИРДАХ ШИЛМЭЛ СТРАТЕГИТЭЙ БАЙСНЫГ ТҮҮХ ГЭРЧИЛНЭ

(Түрүүч нь I нүүрт)

Та Монголын Ардын Армитай анх хэрхэн холбогдож байв?

Би 1935 онд төрсөн хүн. Булган аймгийн Баян-Агт суманд хэлмэгдүүлэлтийн хар шуурга ид хүчээ авах болсон тэрхүү цаг үед төрсөн эцэг, эхээсээ хагацаж өөр айлд өргүүлж байлаа. Миний бага нас феодалын нийгмээс хараахан гараагүй байх үеийн уур амьсгал дунд өнгөрсөн. Гагцхүү тэр шилжилтийн цаг үед ёстой л нэг эрхийг биш бэрхийг сурч чадсан нь хожим цэрэг, армитай холбогдох сэдлийг төрүүлж 13 настайдаа Улаанбаатар хотыг зорьж, Д.Сүхбаатарын нэрэмжит Офицерын сургуульд элссэн. Ингээд бодоход миний бие 70 гаруй жилийг жинхэнэ цэргийн хүний амьдралаар амьдарчээ. Бага балчир наснаасаа өдийг хүртэл хэзээ ч энгийн хүний амьдралыг үзсэнгүй. Энгийн сургуульд сурч, энгийн нэгэн шиг сэтгэж үзсэнгүй. Монгол Улсын Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдаад 100 жил болоход үүний ихэнх цаг хугацаатай миний амьдрал салшгүй холбоотой явжээ. Эцэст нь дүгнэхэд хөлийг минь дөрөөнд, гарыг минь ганзаганд хүргэж, өдий багаас минь тосож авсан нь Монгол Ардын Арми байлаа. Тиймээс энэ салбарт би талархаад баршгүй. Олон шилдэг дарга нарын цэрэг нь болж, олон сайхан цагаа сайн санаж байна. Тэр үеэс л эхэлж энэ том айлд "хүү" нь болж орж ирсэн дээ.

Монголын Ардын Армид алба хаасан он жилүүд танд юуг зааж сургаж, юуг ойлгуулсан бэ?

Би сүүлийн үед өөрийн өнгөрүүлсэн амьдралаа эргэцүүлж бодох болсон. Тэгэхдээ хий дэмий бодож суух биш өөрийн дурдатгал бүтээлээ бичиж эхлээд байна. Бичиж буй энэ дурдатгалаа "Их хүмүүсийн дунд" гэж нэрлэсэн. Яагаад энэ нэрийг өгсөн бэ гэдэг нь учиртай. Анх 13-тайгаасаа энэ салбартай холбогдоход надад зааж, сургаж байсан багш нар, тухайн үед амьд сэрүүн байсан Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтнүүдийн үгийг сонсож, аавын минь оронд аав, ахын минь оронд ах болсон хүмүүсээс амьдралын мөн чанарыг анх сурч байлаа. Жишээ дурдахад, тухайн үед Офицеруудын сургуулийн захирал байсан Д.Сүхбаатарын хүү С.Галсан хурандаагаас эхлээд маршал Х.Чойбалсан, хурандаа генерал Б.Цог, хурандаа Г.Бумцэнд зэрэг эх оронч удирдагчдын дор алба хааж байснаараа үргэлж



Хувьсгалт тэмцлийн зүтгэлтнүүд, тухайн үеийн анхдагч генералууд, "Алдар" нийгэмлэгийн спортын дасгалжуулагч нарыг нэрлэмээр байна. Хүнд хэцүү цаг үетэй нүүр тулсан байлаа ч тэдгээр хуучны эрхэм хүмүүсийн үгийг сонсож, ухаарч явсан цаг хугацааг би ямагт үгүйлж явах болно. Харин энд нэг хүнийг дурдахгүй байхын аргагүй. Тэр хүн бол ард түмэндээ залуу жанжин нэрээр алдаршсан, хурандаа генерал Ж.Лхагвасүрэн гуай юм. Энэ хүнтэй би ойр ажиллаж байгаагүй ч гэсэн сургажигч үгс нь одоо ч миний толгойд байдаг. ЗХУ-ын В.В.Куйбышевийн нэрэмжит Цэргийн инженерийн академид суралцаж байх үед буюу 1964 онд аав минь нас барсан талаар цахилгааныг хүлээн авлаа. Тэр даруй нутагтаа очин оршуулгын ажил явдалд нь оролцоод долоо хоногийн дараа буцаад сургуулиа даа явах гэтэл "Сайд чамайг сургуулиас чинь хөөнө гэж байна" гэсэн үг чихэнд хүрэв.

Тухайн үед Батлан хамгаалахын сайдаар Ж.Лхагвасүрэн гуай байсан цаг. Чухам ямар учир шалтгаантайгаар намайг сургуулиас хөөх болсныг ер ойлгосонгүй. Би ЗХУ руу сургуульд явахнаасаа өмнө "Алдар" нийгэмлэгт сагсан бөмбөгийн хичээл заадаг байхад Ж.Лхагвасүрэн гуайн хүүхдүүд манай дугуйланд хичээллэдэг байсан учир сайдтай эчнээ танил. Гэрт нь ч хэд хэдэн удаа очиж байсан. Тэр үйл явдлын дараахан гэрийнх нь урдхан тааралдахад би хамаг болсон үйл явдал, зовлон жаргалаа нэгд нэгэнгүй тоочлоо. Тухайн үед Ж.Лхагвасүрэн гуай миний асуудлын талаар ерөөс мэдэхгүй байснаас

Та ЗХУ-д В.В.Куйбышевийн нэрэмжит Цэргийн инженерийн академид суралцаж байсан талаараа дурслаа. Тухайн үед хүн болгон л "хойно" сурахыг мөрөөддөг цаг үе байсан шүү дээ ...

Тухайн үед хойно сургуульд сурна гэдэг маш том нэр хүндийн баталгаа байлаа. Би "Алдар" нийгэмлэгт ахлагч байхдаа ЗХУ-ын Ленинград хотын Цэргийн биеийн тамирын сургуульд явах өргөдлийг хоёр удаа өгөөд ямар нэгэн шалтгаанаар хоёулангаас нь татгалзсан хариу авсан. Тэр үед хэдийнээ ханьтайгаа учирчихсан, том хүү нэг настай байсан үе таарсан учир амьдралаа дээшлүүлэх арга бодохгүй бол болохгүй нь гэсэн шийдвэрт хүрч Батлан хамгаалах яаманд өргөдөл өгтөл барилга-инженерийн чиглэлээр сургуульд сурах боломж гарч ирэх нь тэр. Энэ мэдээг хөдөө байдаг эцэг, эхдээ дуулгаад, маргааш нь ЗХУ-ыг зорьж байлаа.

Цэргийн инженерийн академид бид дөрвүүлээ орсон. Сургуулийн зүгээс бид дөрвөөс дөрвөн хичээлээр шалгалт автал орос хэлээс бусад гуравт нь муу үнэлгээ авчихсан болохоор заавал бэлтгэл ангид суралцах ёстой болов. Гэтэл хичээлийн жилийн нээлт эхлэх үед сургуулийн захирал, хурандаа генерал А.Д.Цирлин гэдэг хүн бид дөрвийг хүлээн авч уулзлаа. Тэр хүн монгол орны талаар сайн мэддэг, дайны жилүүдэд Байгаль нуурын цэргийн тойргийн Инженерийн газрын дарга байсан гэж хэлэв. Тэгээд асуудалтай зүйл байна уу гэхэд нь бид шууд нэгдүгээр күрсэд орох хүсэлтэй байна гэдгээ хэллээ. Сургуулийн захирал хүсэлтийг

эх орондоо барилга-инженерийн чиглэлээр олон жил ажилласан мэргэжилтнүүд байсан. Тиймээс ямар ч инженерийн мэдлэггүй миний хувьд ангийнхнаасаа сурлагаар хоцрохгүйн тулд олон шөнө нойргүй хонож байж сургуулиа төгссөн.

1970 онд Ардын Армийн Жанжин штабын бүтэц, орон тоонд өөрчлөлт орж Инженерийн хэлтсийг байгуулахад та анхных нь даргаар томилогдож байсан. Өнөө цагт энэ хэлтэс Зэвсэгт хүчний Барилга-Инженерийн цэргийн удирдах газар болтлоо өргөжсөн байна. Та Зэвсэгт хүчний Барилга-Инженерийн цэргийн ирээдүйн хандлагыг юу гэж хардаг вэ?

Олон улсын жишгээс харахад, өнөө цагийн батлан хамгаалах бодлого гэдэг өөрөө маш өргөн хэмжээний ойлголт болсон. Олон төрлийн цэргээс бүрдэхээс гадна улсын эдийн засагт нөлөөлөх том ач холбогдолтой салбар болсон. Ялангуяа манайх шиг улс төрийн үзэл баримтлалаар төвийг сахисан орны хувьд барилга-инженерийн цэрэг бол үндэсний аюулгүй байдал, стратегийн гол зүрх болж хөгжих боломжтой. Улс орны нууцын асуудал гэдэг чухал. Тэр журмаараа улсын нууц, үндэсний аюулгүй байдлын эрх ашгийг хамгаалан бэхжүүлэх цэрэг-стратегийн байгууламжуудыг барьж байгуулж, бүтээдэг тусгай зохион байгуулалт, өргөн хүрээний том систем болж хөгжих боломж бий. Өөрөөр хэлбэл Монгол Улсын дэд бүтцийг хөгжүүлэх чухал, бие даасан салбар болох ёстой гэж хардаг.

Та 1989-1990 онд буюу Ардчилсан хувьсгал ид хүчээ авч байсан үеийн Батлан хамгаалахын сайд. Тухайн үед ардчилсан хөдөлгөөний цуглаануудыг нэг мөсөн цэргийн хүчээр тараах талаар яригдаж байсан гэдэг. Шийдвэр гаргах сайд хүний хувьд тун амаргүй үе байсан биз ...

Энүүхэндээ хэлэхэд Батлан хамгаалахын сайдын албан тушаалыг хашсан цаг хугацаанд олигтой ажил хийж чадаагүй. Энэ талаар дурсах ч дургүй. Учир нь 1989-1990 он эргэлтийн жилүүд байлаа. Батлан хамгаалахын сайдаар долоон жил ажилласан хурандаа генерал Ж.Ёндон гуайгаас ажил хүлээн авахтай зэрэгцээд иргэдээс ч тэр, армийнхнаас ч тэр шинэ уур амьсгал мэдрэгдэж эхэлсэн. Ер нь түүнээс ч өмнө залуучуудын хандлага, үзэл суртал өөрчлөгдсөн. Зарим орны Засгийн газар огцорч шинээр засаглалууд бие болж байлаа. Энд тэндгүй бослого, үймээн гарч, Европын зарим нэг орны төрийн тэргүүндтэй холбоотой эдрээт хэргүүд гарч эхлэв. Москва хотын К.Е.Ворошиловын нэрэмжит Зэвсэгт хүчний Жанжин штабын академид надтай хамт сурч байсан Чехословакийн Батлан хамгаалахын сайдтай холбоотой байсан учир түүнээс мэдээлэл сайн авч байлаа. Тэр үед байдал их төвөгтэй болсныг мэдэрсэн. Хэдий тийм боловч Ж.Ёндон сайд надад итгэл хүлээлгэж байхад би үгүй гэж хэлэх эрх байгаагүй. Тэгээд сайдын ажлыг авснаас хойш гурван сарын дараа Ардчилсан хувьсгал гээчтэй нүүр тулгарсан

даа. Тухайн үед Армийн хэмжээнд маш их ядуурал бий болсон. Алба хаагчид аргагүйн эрхэнд банкинд өр тавьж эхэллээ. Эдийн засгийн тэр хүндрэлтэй байдлаас шалтгаалж цэргүүдийн хүнсний нормын махыг хүртэл багасгаж байсан хэцүү цаг үе. Үүнээс шалтгаалж маш олон хүн энэ салбараас бэлтгэлээр халагдаж байлаа. Сүүлдээ Ш.Жадамбаа бид хоёрыг энэ хувьсгалын ард байгаа мэтээр маш их дарамт шахалт дээд удирдлагаас ирдэг боллоо. Ц.Элбэгдорж, Т.Ганди гэсэн хүмүүсийн талаар байнга асууж шалгаана. Мөн "Улаан-Од" гэж ямар учиртай байгууллага вэ гэсэн асууллауд өдөр бүр ирнэ. Миний ганц баримталж байсан бодлого бол алба хаагчдаа задраахгүй байх, энэ салбараа бүрэн бүтнээр нь авч үлдэхэд анхаарч байсан. Харин тэр их дарамт шахалт, гүтгэлгийн дунд ажлаа хийж өрөөс чадахгүй болов. Эцэст нь би намын гишүүн байх эрхээсээ татгалзахаар шийдээд намын батлах үнэмлэх дээрээ "Дурсгав" гэсэн тамга даруулж аваад нөгөөдөр нь ардчилсан хүчнийхнийг хүлээж авч уулзахаар боллоо. Тэр үед Ардчилсан хувьсгалын манлайлагч нарыг өрөөндөө дуудуултал Дарь Сүхбаатар, Д.Дорлигжав тэргүүтэй 3-4 хүн ирэв. Би тэдэнд ганц л зүйлийг хатуу анхааруулсан нь "Та нарын үзэл бодлыг буруутгахгүй. Тэмцлээ үргэлжлүүлэхийг эсэргүүцэхгүй. Тэгэхдээ миний цэрэг хөдөлгөх эсэх нь та бүгдээс бүрэн хамаарна. Монгол цэрэг хэзээ ч ард түмнийхээ өөдөөс буу шагайж үзээгүй. Гэсэн хэдий ч хэрвээ та нар манай цэргүүдэд ямар нэгэн байдлаар халдаж, гэмт хэрэг үйлдэж, хүйтэн зэвсэг ашиглаж хүний аминд хүрсэн тохиолдолд би эрх мэдлийнхээ хүрээнд Монголын армийг ямар ч эргэлт буцалтгүй хөдөлгөөнөөс өөр аргагүй шүү" гэж хэлсэн. Миний шаардлагыг хувьсгалын удирдагч нарын нэг С.Зориг маш сайн хүлээн авсан гэж боддог. Үүний дараагаар ч бид хоёр хоорондоо холбоотой ажилласан. Ард түмнийг ямар нэгэн байдлаар хүч зэрэглэх боломж өгч болохгүй талаар би байнга сануулдаг байлаа. Ийнхүү 1990 оны 8 дугаар сард би өөрийн хүсэлтээр ажлаа өгч бэлтгэлээр халагдсан юм даа.

Ер нь цэргийн хүн ямар зарчмыг баримталж, бусдаас юугаараа ялгаж хэрэгтэй гэж та боддог вэ? Зэвсэгт хүчний ирээдүй болж явах залуучуудад юуг захиж хэлэх вэ?

Нэгдүгээрт, цэргийн хүн цэрэг л байх ёстой. Өөрөөр хэлбэл цэрэг хүн өөртөө үнэнч байхаас бүх зүйл эхэлнэ. Тиймээс шударга байх нь хамгийн эрхэм чанар. Дараагаар нь цэргийн алба гэдэг тэр чигээрээ нөхөрлөлийн алба. Бусдад худал ярьдаг, ардуур хойгуур нь муулдаг хүн энэ салбарт хэзээ ч тохирохгүй. Дээрээс нь энэ бол хүндлэлийн алба. Ахлах дарга ч тэр, цэргээ ч тэр хайрлаж, хүндэлж байдаг өвөрмөц ёс зөвхөн цэргийнхэнд бий. Түүрүүнд хэлсэн шиг монгол цэрэг хэзээ ч өөрийн ард түмний өөдөөс буу сэлэм далайж байгаагүй, хэзээ ч жагсаалын дуугаа мартаагүй. Их Монгол Улсын үеэс эхлэлтэй сахилга, зохион байгуулалт, дайчин уламжлал өнөөдөр ч гэсэн Зэвсэгт хүчинд өвлөгдөж ирсний нэг баталгаа бол манай цэргүүдийн аливаа нөхцөл байдалд түргэн хугацаанд дасан зохицох чадвар гэж би хардаг.

Монголчууд дэлхийн талыг байлдан дагуулж байсан үеэсээ сул байсан хэдий ч цаг үе, орчин нөхцөлтэйгөө бүрэн зохицсон шилдэг цэргүүд, тэднийг удирдах шилмэл стратегитэй байсныг түүх гэрчилнэ. Тиймээс монгол цэрэг гэдэг тун өвөрмөц онцлогтой юм шүү гэдгийг хойч үеийн залуучууд ухаарах хэрэгтэй. Энэ салбарт ажиллаж байгаадаа мөнхөд бахархаж явах нь тангараг өргөсөн цэргийн хүний баримтлах ёстой зарчим. Дээрээс нь цэргийн хүн бусдаас түрүүлж өөрийгөө таних хэрэгтэй. Бусдын дунд би хэн юм бэ гэдгийг байнга бодож явах нь чухал. Мөн ахмад үеэсээ байнга суралцаж бай гэж захимаар байна. Тэгж гэмээ нь залгамж халаа гэдэг зүйл бий болдог учиртай.

Дэд ахлагч Т.ИДЭР



бахархдаг. Энэ он жилүүд надад бусдыг хүндлэх, өөрийгөө таних зэрэг жинхэнэ цэрэг хүний эзэмших ёстой чадваруудыг суулгаснаас гадна энэ эрхэм хүмүүс хүн байхыг үлгэрлэсэн хэрэг.

Та сая эх оронч удирдагчдын дор алба хааж явсан гэлээ. Таны хувьд хамгийн шилдэг дарга таны хэн байв?

Нэрлээ гэвэл олон хүн санаанд орж байна. Захаас нь дурдахад, Д.Сүхбаатараас бусад бүх

гадна нөхцөл байдлыг ухаалгаар ойлгож буцаад сургууль руу минь явах боломжийг бүрдүүлэхэд тусалж байсан. Намайг сургуулиас хөөнө гэсэн яриа бол зүгээр л академид явах хүсэлтэй хэн нэгнээс худал цуу тараасан болж таарсан. Сүүлд бодоход Ж.Лхагвасүрэн гуайн хэлж байгаа үгс яах аргагүй олон зэвсэгт мөргөлдөөнд орж, эх орноо хамгаалан баатарлагаар тулалдаж байсан жинхэнэ эх оронч гэж хэн байх ёстойг харуулдаг байлаа.

хүлээн авч бид нэгдүгээр күрсээ орж чадсан юм даа. Гэтэл бэлтгэл ангид сураагүйн гай хагас жилийн шалгалтаар мэдрэгдлээ. Бид дөрөв шалгалтдаа уначихсан, цааш сурахад хэцүүхэн байлаа. Нөгөө гурав маань бүүр шантарчихсан, буцаад нөгөө бэлтгэл ангидаа сурах хүсэлтээ өгсөн.

Харин би 4-5 улсаас ирсэн 15 хүнтэй ангид ганцаараа монгол болж таарав. Дээрээс нь манай ангийнхан бүгдээрээ өөрсдийн

Л.Алтанбаяр: БИ ЦЭРГИЙН АЛБЫГ ДУНДАРШГҮЙ ДАЛАЙ ГЭЖ ХАРДАГ

Улс орны хэмжээний бүтээн байгуулалт бол аль ч цаг үеийн залуу үеийнхний гар, бие оролцох ёстой талбар юм хэмээн яриагаа эхлэх түүнийг Лхагва-Эрдэнэ овогтой Алтанбаяр гэдэг. Тэрээр Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн инженер сапёрын ротын инженер сапёрын салааны тасгийн захирагч. Зэвсэгт хүчний 2020 оны Тэргүүний цэргийн гэрээт алба хаагчаар шалгарсан нэгэн юм.

Зэвсэгт хүчин хэмээх их айлд нэг жилийн хугацаанд 200 хол давсан цэргийн гэрээт алба хаагч алба хаадаг. Тэр олон дундаас шалгарч, тэргүүний цэргийн гэрээт алба хаагч болно гэдэг түүнээс маш олон талаараа шилдэг байхыг шаардсан нь дамжиггүй. Дуудах нэрийг эцэг эх, дуурсах алдрыг өөрөө олж авна гэдэгчлэн Монгол Улсын Зэвсэгт хүчинд “тэргүүн” хэмээн дуудах нэр хүндийн төлөөх хөдөлмөр, зүтгэлийг биеэрээ харуулж яваа түүнтэй ярилцсанаа хүргэж байна.

“Соёмбо” сонины уншигчдынхаа өмнөөс танд Зэвсэгт хүчний 2020 оны Тэргүүний цэргийн гэрээт алба хаагч болсонд баяр хүргэе. Тэргүүний цэргийн гэрээт алба хаагч болсонд хамгийн их нөлөөлсөн зүйл тань юу байв ...

-Баярлалаа. Зэвсэгт хүчний болон ангийнхаа нийт бие бүрэлдэхүүнд шинэ оны мэндийг хүргэе. Цэргийн хүн болох бага насны мөрөөдлөө биелүүлж яваагийн зэрэгцээ Зэвсэгт хүчний шилдэг цэргийн гэрээт алба хаагч болсондоо үнэхээр их баяртай байна. Шилдэг болсон нь Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн хамт олны зааж зааварласан бүхний үр шим төдийгүй Монгол Улсын бүтээн байгуулалтын ажилд гар бие оролцсон явдал маань энэ эрхэм хүндтэй шагналын эзэн болоход нөлөөлсөн.

Бүтээн байгуулалтын ажилд ямар үүрэг гүйцэтгэж оролцсон бэ?

-Зэвсэгт хүчний 7782 дугаар ангид хуваарилагдан, хэд хэдэн ажлыг дэс дараатай гүйцэтгэсэн. Эхний ээлжинд төмөр замын бүтээн байгуулалтын зам гүүр, хоолой хийц угсрагч гэсэн албан тушаалд томилогдон 34 км төмөр замд 34 ширхэг гүүр хоолойн угсралт буюу их биеийн арматурчлал, цутгалтын хоолойг хийж гүйцэтгэсэн. Дараа нь гүүр хоолой, хийц угсрагч бүлгийн даргаар томилогдон төмөр замын дэд бүтцийн ажил, дээд үе болон дэр бетон дэвсэх ажлыг хийсэн. Энэ нь 55 км төмөр замын асфальт болон дэр бетоныг тавих зэрэг ажил юм.

Хэдий хэрийн хугацаанд дээрх ажлуудыг гүйцэтгэсэн бэ? Цаг агаар болон нөхцөл

байдал тухайн үед ямар байсан бол ...

-Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаалаар ангийнхаа зарим бие бүрэлдэхүүний хамт өнгөрсөн оны 2 дугаар сарын 27-ны өдрөөс 10 дугаар сарын 18-ны өдрийг хүртэлх хугацаанд томилогдсон. Зундаа маш халуун, хавар, намартаа их салхитай, өвөлдөө хүйтэн нөхцөлд ажилласан. Энэ нь ямар ч нөхцөлд өгөгдсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь гүйцэтгэх дадлага, туршлага болсон. Сурч мэдэх, мэргэших, өгөгдсөн үүрэг, тушаалын дагуу ажиллах нь бидний үүрэг, бас асар том хариуцлага учир ямар нэг шалтаг тоочиж хойш суух хүн тэнд нэг ч байгаагүй. Ер нь улс эх оронд өрнөж байгаа бүтээн байгуулалтын ажилд залуучууд бидний оролцоо их байдаг юм билээ. Мөн албаа хааж байх хугацаандаа тэр том ажилд оролцоно гэдэг ховор боломж юм.

Нээрээ л тийм шүү. Нууц биш бол хэдэн төгрөгийн цалин авсан бэ?

-Төмөр замын бүтээн байгуулалтын сарын цалин 2.1 сая төгрөг байсан. Үүн дээр цэргийн гэрээт албаны цалин мөн бодогдсон. Тиймээс би багагүй мөнгөн хуримтлал бүрдүүлж, үүнээсээ гэр бүлдээ тодорхой хэсгийг зориулж үлдсэнийг нь хадгалсан. Ирээдүйд өөртөө оюуны хөрөнгө оруулалт хийх төлөвлөгөөтэй байна.

Оюуны хөрөнгө оруулалт хийнэ гэсэн санаа чинь их таалагдаж байна вэ?

-Би дээр хэлсэн дээ, цэргийн хүн болох нь миний багын мөрөөдөл гэж. Тиймээс анхнаасаа Зэвсэгт хүчний 029 дүгээр ангид хугацаат цэргийн



алба хаасан. Хугацаат цэргийн алба хаах хугацаандаа цэргийн хүн болох зорилго маань улам баталжсан. Нэг жил үнэхээр хурдан өнгөрсөн. Тиймээс үүнийхээ дараа саналаараа цэргийн гэрээт албыг хаахаар шийдсэн маань энэ. Цэргийн анги миний байх ёстой газар, цэргийн алба миний хаах ёстой алба юм билээ. Бүх зүйл нь дотно санагдахын зэрэгцээ албандаа улам илүү дурлаж цэргийн эрдэмд шамдан суралцаж байна. Цэргийн гэрээт албаа хаачаад би офицер болно гэж бодож байгаа.

Цэргийн гэрээт албанд ирээд их олон зүйлд суралцжээ. Энэ бүхэнд суралцахын суурь нь юу байв гэж харж байна вэ?

-Цэргийн гэрээт албанд орсноор амьдралд минь томоохон өөрчлөлт гарсан. Тухайлбал, тэсвэр тэвчээр, хатуужил, дэг журамтай болохын зэрэгцээ хувийн зохион байгуулалттай ажиллаж сурсан. Мөн үүний цаана гарвал юу байгаа бол гэсэн суралцах хүсэл тэмүүлэлтэй болсондоо их олзуурхдаг. Би цэргийн албыг дундаршгүй далай гэж

хардаг. Хичээж, өөрийгөө дайчилж чадвал эндээс сурах зүйл үнэхээр их. Анх энэ ангид ирэхэд манай ангийн захирагч “Гэрээт цэрэг гэрэлтэй алба шүү” гэж хэлж байсан. Тухайн үед нэг их ойлгоогүй. Харин одоо тэр хэлсэн үгийн үнэнийг үнэхээр мэдэрч байна.

Алба хааж байгаа анги тань юугаараа таны сэтгэлийг татдаг вэ?

-Цэргийн гавьяаны улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 014 дүгээр анги маань Инженерийн цэргийн тусгай хороо гэх нэрээр алдар нь түгсэн байдаг юм билээ. Энэ ангид алба хааж байгаадаа маш их баяртай байдаг. Мөн манай анги Монгол Улсын энх цагийн бүтээн байгуулалтад бусад нэгтгэл, ангиудтай хамтран асар том дэмжлэг үзүүлж байна. Ажлыг хийж бүтээх туршлагатай, нэгдэж ажиллаж чаддаг, ирээдүйгээ харж, төлөвлөж чаддаг, маш сайн бие бүрэлдэхүүнтэй анги. Ямар азаар энэ ангид цэргийн гэрээт алба хааж байгаа юм бэ гэж нэг биш удаа бодож байсан.

Хошууч Д.ОЮУНГЭРЭЛ

Цэргийн гэрээт алба танд ямар боломж олгох вэ

➤ Дэлхийн жишигт цэргийн алба хаахыг үүрэг болгосон, сонголт болгосон гэсэн хоёр үндсэн хувилбар үйлчилдэг. Монгол Улсын иргэний хувьд цэргийн алба хаах нь эрчүүдийн үүрэг бөгөөд заавал хаахаар хуульчилсан.

➤ Манай улсын хувьд цэргийн гэрээт албыг байлдагч, түрүүчээр хаах хугацаа 24 сар. Гэрээний хугацааг хоёр жилээр 31 нас хүртэл сунгаж болдог. Мөн иргэн цэргийн байгууллагад шаардлагатай мэргэжил, албан тушаалд ахлагч, офицероор тав хүртэл жилийн хугацаагаар цэргийн гэрээт алба хааж болдог.

➤ Ц э р г и й н гэрээт алба хаагчийн цалин нь үндсэн цалин, цэргийн цолны цалин, онцгой нөхцөл, цэргийн мэргэжлийн зэрэг, хилийн болон хууль тогтоомжид заасан бусад нэмэгдлээс бүрддэг. Ойролцоогоор 350-400 мянган төгрөгийн цалинтай, нэг ёсондоо ажлын байраар хангагдаж байна гэсэн үг.

➤ Цэргийн гэрээт албаны байлдагч, түрүүчийн алба хаасан хугацааг иргэний нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаанд оруулж тооцдог. Цэргийн гэрээт албаны ахлагч, офицерын алба хаах хугацаанд иргэний нийгмийн даатгалын шимтгэлийг төр хариуцдаг.

➤ Монгол Улсын Зэвсэгт хүчинд алба хааж байгаа цэргийн гэрээт албаны байлдагчид бүтээн байгуулалтын ажилд оролцож болно. Өнгөрсөн 2020 онд хийгдсэн төмөр замын бүтээн байгуулалтын ажилд 400 гаруй цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагч оролцож, тус бүр 8-13 сая орчим төгрөгийн хуримтлалтай болсон юм.

ЭЭЖ НЬ ЧНСБЕ, ХАЦРАА ӨГ ДӨӨ



Цар тахлын энэ хүнд цаг үед цэргийн албанд хүүгээ мордуулсан мянга мянган ээж, алба хааж буй дайчдын төлөөлөл болгож Дархан-Уул аймгаас хугацаат цэргийн албанд татагдан Зэвсэгт хүчний 013 дугаар ангид алба хааж буй байлдагч Г.Жавхланг ээж Н.Гэрэлзэтэй нь цахимаар холбосон юм.

Хүү: Сайн байна уу ээж ээ, сайхан өвөлжиж байна уу?

Ээж: Сайн сайн. Миний хүүгийн цэргийн алба нь өндөр үү?

Хүү: Сайн байгаа. Та нар минь сайн уу?

Ээж: Бүгд сайн, ажил төрлөө хийцгээгээд байж байна. Миний хүүгээр сонин сайхан юу байна вэ?

Хүү: Хүүг нь дарга яриулж байна аа. Хүү нь шинэ жилийн баярт зориулсан шилдэг ханын сонин шалгаруулах уралдаанд амжилттай оролцож өвлийн өвгөний бэлэг авсан.

Ээж: Баяр хүргэе хүүдээ. Мундаг шүү.

Хүү: Нутгаар сонин сайхан юутай вэ? Корона их л байх шиг байна, та нар давгүй биз дээ ...

Ээж: Харин тийм ээ. Бид давгүй. Миний хүү маскаа зүүж, гараа сайн угааж байгаарай.

Хүү: Бидэнд байнга зөвлөмж, зааварчилгаа өгч байгаа. Бас дархлаа дэмжих аарц, чацарганын шүүс өгдөг. Өдөр бүр ангийн эмч, сувиллагч нар халуун хэмжиж, ариутгал, халдваргүйжүүлэлт тогтмол хийдэг учраас санаа зоволтгүй.

Ээж: Энд саяхан их хүйтэрсэн. Хотод хүйтэн байна уу?

Хүү: Ойрд нэлээн хүйтэрсэн. Одооноос гайгүй болж байна. Дүү нар сайн уу?

Ээж: Сайн сайн. Гэрээс гарахгүй теле хичээлээ хийцгээж байна.

Хүү: За, ээжээ биеэ сайн бодоорой. Хүүдээ санаа зоволтгүй ээ.

Ээж: Миний хүү бас биеэ сайн бодож, дулаан хувцсаа өмсөж, алба сайн хаагаарай. Ээж нь ковид байхгүй болохоор хүү дээрээ очно оо.

Хүү: Тэгээрэй.

Ээж: Хүүдээ хайртай шүү. Ээж нь үнсье, хацраа өг дөө.

Хүү: Хүү нь бас хайртай шүү. Баяртай ээжээ. Дараа холбогдье. Эх үрс бүхэн эрүүл саруул, сэтгэл амгалан байг ээ.

Дэд хурандаа Х.ГАНЗУЛ

“COVID-19” УЛС ОРНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХААШАА ХӨТӨЛЖ БАЙНА ВЭ



(Түрүүч нь I нүүрт)

Өнгөрсөн 3 дугаар сард НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутерриш дэлхий нийтэд нүүрлээд буй “COVID-19” цар тахлын нөхцөл байдлаас улбаалан улс гүрнүүд энх тайвныг эрхэмлэж, улс төрийн болон зэвсэгт мөргөлдөөнүүдийг зогсоохыг уриалсан. Уг санаачилгыг Колумбын Үндэсний чөлөөлөх арми, Камеруны зэвсэгт босогчид зэрэг зарим бүлэглэл, Зэвсэгт хүчин дэмжиж сүүлийн долоон сарын хугацаанд ямар нэгэн идэвхтэй үйл ажиллагаа явуулаагүй тул дээрх газруудад цагийн байдал харьцангуй тогтворжээ. Нөгөөтэйгүүр улс төрчдийн шийдвэр, оролцоогүй Афганистан, Сири улсад цагийн байдал намжиж байгаа нь цар тахлаас үүдэлтэй гэж зарим судлаач үзэв. Гэвч дэлхийн эдийн засаг хямарч, ядуурал, ажилгүйдэл бүх улсад

нүүрлэсэнээр эмх замбараагүй байдал үүснэ гэж шинжээчид үзэж байна.

Эдийн засгийн тогтворгүй байдал, улс орнуудын үл ойлголцлоос үүдэж томоохон дайн дэгдэхийг ч үгүйсгэх аргагүй. АНУ, Европын холбоо, Япон зэрэг НҮБ-ын донор орнууд эдийн засгийн хямралд хүчтэй өртсөнөөр НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны санхүүжилт буурч, энх тайвны төлөө хүчин чармайлт хумигдсаар байгааг онцлох учиртай. Энэ нь зэвсэгт босогчид, террорист бүлэглэлүүдэд өөрсдийн үйл ажиллагаагаа идэвхжүүлэх боломжийг олгож, эрх мэдлээ бэхжүүлэх, ахиулах, өрсөлдөгчөө доройтуулах боломжоор хангаж байна.

**А ж и л г ү й д э л ,
ядуурлыг ашиглаж
Исламын улс, Боко Харам
болон бусад орон нутгийн**

**зэвсэгт бүлэглэлүүд
үйл ажиллагаагаа
идэвхжүүлж, хүчээ
улам зузаатгах болов.
Ялангуяа Исламын улс
террорист бүлэглэл
“COVID-19”-ийг зэвсэг
болгон ашиглаж,
д э м ж и г ч д э э р э
дамжуулан вирусийг
тарааж, террорист
х а л д л а г у у д ы г
э р ч и м ж ү л э х и й г
илт уриалж эхлээд
байна. Үүний дүнд
тус байгууллагатай
холбоотой хүчирхийлэл
Ирак, Мозамбект
нэмэгдэж, Йемен, Ливи
зэрэг улсад зөрчил,
мөргөлдөөн тогтмол
гарч, орон нутгийн
зэвсэгт бүлэглэлүүд**

газар нутгийн хяналт, эрх мэдлээ чангатгах, иргэдийн шилжилт хөдөлгөөнд саад учруулж, олон улсын хүмүүнлэгийн байгууллагын үйл ажиллагааг ихээр тасалдуулах болжээ. Цар тахал дэгдсэн 2020 оны нэгдүгээр улирлаас оны төгсгөл хүртэл хугацаанд дэлхийн хэмжээнд зэвсэгт мөргөлдөөн ойролцоогоор 30 хувиар нэмэгдсэн нь олон улсын аюулгүй байдалд “COVID-19” хэрхэн муугаар нөлөөлж байгааг харуулж байна.

Олон улсын эдийн засгийн шинжээч Седрик де Конингийн тэмдэглэснээр, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны санхүүжилт 2008 оны санхүүгийн хямралын үеэр төсөв нь 20 орчим хувиар буурч байжээ. Харин энэ удаагийн цар тахлын улмаас энэхүү төсөв 30 орчим хувиар дахин буурах хандлагатай байна гэж онцолсон.

тодорхойлогддог. Гэтэл хатуу хөл хорионы дэглэмийг дэлхийн ихэнх улс мөрдсөнөөр хүн төрөлхтний түүхэнд өмнө нь байгаагүй эрх чөлөөний хязгаарлалт тогтлоо.

Дэлхийн хамгийн том эдийн засагтай АНУ, БНХАУ хоёрын харилцаа цар тахлын дараа ч муудсан хэвээр байх төлөвтэй байна. Ялангуяа “COVID-19”-ийн дэгдэлтэд хоёр улс бие биеэ хүчтэй буруутгаж байгаа нь байдлыг улам төвөгтэй болгож, бүс нутагт хямралт байдал үүсгэх боллоо. БНХАУ-ын дарга Си Жинпин 2021 оны нэгдүгээр тушаалдаа Зэвсэгт хүчний бүх нэгтгэл, ангиудыг бэлтгэл сургуулилт хийх шийдвэр гаргаж, дайнд бэлтгэхэд болон сургалтад онцгой анхаарахыг үүрэгдсэн. Энэ нь цаашдаа бүс нутагт дайн дэгдэж болохыг анхааруулсан төрийн тэргүүний сануулга гэдгийг шинжээчид онцолж байна.

Цар тахлын дараах ирээдүйг хэн ч хэлж мэдэхгүй. Гэхдээ Европын холбооны Геополитикийн дүн шинжилгээний хэлтсийн мэргэжилтэн Катрин Мустаситагийн онцолсноор, цар тахлын дараа дэлхийн эдийн засгийн уналттай холбоотой ядуурал, хүний эрхийн



Нөгөөтэйгүүр цар тахал нь орчин үеийн соёл иргэншлийн хамгийн үнэ цэнтэй зүйл болох хүний эрх, эрх чөлөөнд халдсан нь хачирхалтай. Дэлхийн ихэнх улсад бидний амьдралын хэв маяг нь хувь хүний эрх чөлөө, нийгмийн харилцаагаар

доройтол, зөрчил мөргөлдөөн үүсэх нь тодорхой бөгөөд улс орнууд үүсэж болзошгүй цагийн байдалд бэлэн байх нь чухал гэж хэлснийг энд тэмдэглэх нь зүйтэй.

Ахмад. М.МӨНХЗОРИГ

COVID-19 ба цэргийн эмч нар

COVID-19 цар тахалтай “дайтж” байгаа алба хаагчдын тэргүүн эгнээнд эмч тэр дундаа цэргийн эмч нар байгааг бид мэднэ. Иймд олон улсад цэргийн эмч нар коронавирусийн эсрэг хэрхэн тэмцэж байгаа тухай мэдээллийг хүргэе.

ИТАЛИЙН ЦЭРГИЙН ЭМЧ НАР КОСОВОД



Италийн Гадаад хэргийн болон Батлан хамгаалахын сайд нарын шийдвэрээр тус улсын цэргийн эмч нар Косовод “COVID-19”-ийн эсрэг ажиллагааг эхлүүлэхээр болжээ. Уг ажлын хүрээнд хоёр орны эмч нарын харилцан туслалцах хөтөлбөр хэрэгжиж тус улсын цэргийн эмч нарын баг Косовод өнгөрсөн долоо хоногос ажиллаж эхэллээ.

Хөтөлбөрийг НАТО-гийн хүчний тэргүүлсэн “KFOR” цэргийн ажиллагааны командлагч, хошууч генерал Мишель Риси удирдаж байна. Халдвар судлаач, уушгины нарийн мэргэжлийн эмч нараас бүрдсэн тус баг нь Италийн хойд хэсэгт коронавирусийн эсрэг маш үр дүнтэй ажиллаж байсан туршлагатай хүмүүс аж. Хоёр улсын цэргийн эмч нар хөтөлбөрийн хүрээнд хамтран ажилласнаар цар тахлын үеийн менежментийн туршлагыг бие биеэсээ суралцах ач холбогдолтой юм.

ОХУ-Д 1000 ГАРУЙ ЦЭРГИЙН ЭМЧ АЖИЛЛАЖ БАЙНА

Өнгөрсөн Мягмар гарагт болсон ОХУ-ын БХЯ-ны хурал дээр тус улсын Батлан хамгаалахын сайд Сергей Шойгу хэлэхдээ, “Мянга гаруй цэргийн эмч эх орондоо болоод хилийн чанадад “COVID-19”-ийн эсрэг тэмцэж байна. Тэд Орос орны өнцөг булан бүрт хүрч, аюулт цар тахлаас эх орноо аврахаар маш үр дүнтэй ажиллаж байна” хэмээн дурдсан.

Одоогийн байдлаар Москва орчмын бүс нутагт Патриот конгресс

үзэсгэлэнгийн төвд 673 цэргийн эмч түр эмнэлэг байгуулан халдвар авсан 1420 хүнийг тусгаарлан эмчилж байна. Тэд өмнө нь 1100 хүнийг эмчилж эдгээжээ.

Сергей Шойгу нэмж тэмдэглэхдээ “Өнгөрсөн 10 дугаар сарын сүүлчээр Москва, Курган мужийн эрүүл мэндийн байгууллагуудад 72 цэргийн эмчийг илгээсэн. Түүнчлэн явуулын хоёр эмнэлэг дэлгэн 133 цэргийн эмнэлгийн мэргэжилтнийг Абхаз, Өмнөд Осетийн бүс нутагт ажиллуулж байна” гэв.

ГУАЖАХАРА ОМОГТ ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЖ ЭХЭЛЛЭЭ



Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас Бразил Улсыг уугуул иргэдээ цар тахлаас хамгаалж чадахгүй байна гэж шүүмжилсэн. Тиймээс Бразилийн цэргүүд шүүмжлэлийн хариуд “COVID-19”-ийн халдварт өртөөд буй Амазоны Гуажахара омогт эмнэлгийн тусламж үзүүлэх гурван долоо хоногийн ажиллагааг өнгөрсөн даваа гарагт эхлүүлжээ.

Цэргийн эмч нар Гуажахара омгийн коронавирусээр хүнд өвчилсөн иргэдийг агаараас эмнэлгийн татан гаргалт хийж, нүүлгэн шилжүүлж байна. Омгийн удирдагчид Засгийн газрыг вирусээс сэргийлэх дорвитой арга хэмжээ авч чадахгүй, алслагдсан газар амьдардаг иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээг

хангалтгүй үзүүлсэн гэж буруутгаад байсан юм. Тус улсын Батлан хамгаалах яамнаас мэдээлснээр цэргийн эмч нар өнгөрсөн 9 дүгээр сараас хойш нийт 370.000 хүнд үзлэг хийж, 39 тонн эм, хоол хүнс, хамгаалалтын тоног төхөөрөмжийг Маранхао мужийн ширэнгэн ойд амьдардаг омгуудад тараажээ.

Гуажахара омог нь байгаль орчны хяналтыг амьдарч буй бүс нутагтаа тавьж, рууль бус мод бэлтгэгчдийг газар нутаг руугаа оруулдаггүй, тэдний эсрэг тэмцдэг “ойн хамгаалагч” хэмээх дайчин хүмүүс гэдгээрээ алдартай.

Одоогийн байдлаар тус улсад “COVID-19”-ийн халдвараар 150 мянган хүн нас барж, 4.9 сая тохиолдол батлагдаад байна.





ХАМГИЙН ОЛОН ЖИЛ ЦЭРГИЙН АЛБА ХААХ ХУУЛЬТАЙ ОРНУУД

Хүн төрөлхтний түүхэнд анх төрт улсууд байгуулагдаж эхэлсэн үеэс цэрэг хэмээх ойлголт бий болсон гэж судлаачид үздэг. “Цэрэг гэдэг нь албадлагын болон сайн дурын үндсэнд цэргийн албанд элсэж, нэгдсэн зохион байгуулалтад орсон

дүрэмт хувцастай хугацаат цэргээс ахлагч, офицер цолтой хүмүүсийг хэлнэ” хэмээн цахим нэвтэрхий тольд бичжээ. Эдүгээ дэлхийн 195 орноос бүх нийтээр цэргийн алба хаадаггүй 109 улс байдаг бол нэг жил хүртэлх

хугацаанд цэргийн албанд татдаг 20 улс байдаг аж. Харин 18 сар хүртэлх хугацаатай цэргийн алба хаадаг 12, 18-аас дээш сараар цэргийн албанд татдаг 18 улс байдаг бөгөөд иргэдээ хамгийн олон жил цэргийн алба хаалгадаг нь Хойд Солонгос юм.

К РОР ОДДЫГ ТҮР ЧӨЛӨӨЛЖ БОЛДОГ

Өмнөд Солонгосын 18-28 насны бүх эрчүүд цэргийн албыг 20 сарын хугацаатай заавал хаах хуультай. Харин Соёлын яамны сайд санал болговол хуулийн дагуу тодорхой К-роп оддыг цэргийн албанаас түр хугацаагаар чөлөөлж болдог. “Соёлын яамны сайдын санал болгосон тухайн поп дуучин нь Өмнөд Солонгос улс болон дэлхийд өөрийн гэсэн өнгө төрхөөрөө танигдаж, олны таашаалыг хүртсэн уран бүтээлч гэж өөрийгөө нотолж чадвал цэргийн алба хаах хугацааг 30 нас хүртэл сунгаж болно” гэж хуульд заажээ. Мөн спортод өндөр амжилт үзүүлж буй тамирчин, сонгодог хөгжмийн уран бүтээлчид энэхүү заалтад багтдаг байна.



дагуу 18 нас хүрсэн эрэгтэй хүн бүр заавал цэргийн мэргэжлийн анхан шатны сургалтад хамрагддаг. Гэхдээ сургалтын хугацааг алба хаасан хугацаанд тооцдоггүй. Ингээд тухайн иргэнийг 19 нас хүрэхэд биеийн тамирын шалгуур үзүүлэлтээр шалгаж цэргийн албанд тэнцүүлдэг журамтай.

Саяхан болсон нэгэн жишээнээс үзвэл тус улсын алдарт “BTS” хамтлагийн гишүүд бүгд тус хуулийн дагуу цэргийн албанаас 30 нас хүртлээ чөлөөлөгдсөн. “BTS” хамтлаг нь өөрсдийн өвөрмөц уран бүтээлээрээ дэлхий дахинаа нэгэнт танил болоод байгаа бөгөөд өнгөрсөн 12 дугаар сард “Грэмми” шагнал хүртсэн хамгийн анхны К-роп хамтлаг болсон. Тэд мөн Биллбоардын 100 шилдэг дууны жагсаалтад багтсан дэлхийн хамгийн анхны англиас өөр хэлээр дуулдаг хамтлагаар нэрлэгдээд байна.

Алба хаах хугацаа нь тэдний ямар мэргэжлийн цэрэгт үүрэг гүйцэтгэсэнээ шалтгаална. Хуурай замын болон Тэнгисийн явган цэргийн салбарт алба хаавал нэг жил зургаан сар, Тэнгисийн цэрэгт алба хаавал нэг жил найман сар, Агаарын цэрэгт алба хаавал нэг жил есөн сар байдаг. Цэргийн албаа хааж дуусаад дайчилгааны бэлтгэл нөөцөд шилжинэ. Жил бүр гурван

өдрийн цэргийн сургалт бэлтгэлд хамрагдаж байх хуулийн зохицуулалттай.

Өмнөд Солонгос нь иргэдээ хамгийн урт хугацаагаар цэргийн алба хаалгадаг орнуудын тоонд багтдаг. Иргэдийн дунд цэргийн алба хаах хугацааг хэт урт байна гэсэн шүүмжлэл ихээр гарах болсон тул сайн дураар алба хаах бодлого руу шилжих ёстой гэж 2010 оноос улс төрчид нь үзэх болов. Гэвч тус улсын Засгийн газрын зүгээс улс орны эрх ашиг, тусгаар тогтнолтой холбоотой ноцтой асуудал болох Чинёон онгоцны сүйрэл болон Ёмпон арал дээр болсон үйл явдлаас улбаалж цэргийн алба хаах хугацааг багасгах ямар ч боломжгүй гэсэн шийдвэр гаргасан байна.

13 ЖИЛИЙН ЦЭРГИЙН АЛБА



Хойд Солонгосын цэрэг татлага дэлхийн улс гүрнүүдийн анхаарлыг татдаг. Жил бүрийн цэрэг татлагыг Хойд Солонгосын Ажилчин намын Цэргийн төв комисс зохион байгуулах үүрэгтэй. Эрэгтэй хүүхэд 14 настайгаасаа цэрэгт алба хаах бэлтгэлд хамрагдаж, 17-30 нас хүртлээ цэргийн алба хаана. Харин улс төрийн өндөр албан тушаалтнуудын хүүхдүүд цэргийн албанаас шууд чөлөөлөгддөг.

Тус улс анхны цэрэг татлагаа Солонгосын дайны өмнө Ким Ир Сений тушаалаар зохион байгуулсан. Тухайн үед санхүүгийн урамшууллын бодлого нь эрчимтэй байсны дүнд сайн дураар цэргийн алба хаах хүсэлтэй иргэд байснаас хэдхэн жилийн дотор дэлхийн хамгийн олон алба хаагчтай армийг бий болгож чадсан юм.

Хойд Солонгосыг дэлхийн хамгийн цэрэгжсэн улс ч гэж нэрлэдэг. Эдүгээ гурван хүн тутмын нэг нь ямар нэгэн цэргийн байгууллагад харьяалагддаг байна. Ким Ир Сенийг төр барьж байхад аль нэг гэр бүлээс хэн нэгэн нь цэргийн алба хаавал төрийн халамжийн илүү таатай бодлогыг хүртэх боломжтой байсан учир цэрэг татлагыг хүчээр зохион байгуулдаггүй байжээ. Гэвч 1993 оноос эхлэн цэргийн алба хаах хугацааг 8 жил байсныг 10 жил болгон сунгаж, цэрэгт татагдсан хүний ар гэр рүү чиглэсэн нийгмийн бодлогоо бууруулснаар аажимдаа цэрэг татлагыг албадлагын журамд шилжүүлжээ.

1958 онд гарсан Ажилчин намын шийдвэрээр

цэрэгт татагдагч нь 3.5 жил Хуурай замын цэрэгт эсвэл дөрвөн жил Тэнгисийн цэрэгт алба хаадаг байв. Гэвч аажимдаа хугацаа уртассаар хамгийн сүүлд 1996 онд намын шийдвэрээр иргэнийг 30 нас хүртэл нь цэрэгт алба хаалгахаар хуульчилсан байна. НҮБ болон бусад олон улсын байгууллага энэ бодлогыг хүчтэй эсэргүүцсээр ирсэн. Тус улсын удирдагч 2003 онд НҮБ-ын Хүний эрхийн хороонд албан тайлбар өгөхдөө “...Бүх нийтийн цэрэг татлага нь иргэдийн сайн

дурын үндсэн дээр зохион байгуулагддаг” гэсэн боловч одоо ч энэ нь эргэлзээтэй юм. Ажилчин намын Цэргийн төв комисс жил бүрийн цэрэг татлагын тоог зааж өгдөг. БНАСАУ-ын Үндэсний батлан хамгаалахын комиссоос бүрэлдэхүүн томилогдож улс орны өнцөг булан бүрт муж, дүүргийн хэмжээнд цэрэг татлагыг удирдан зохион байгуулдаг.

Тухайн иргэн нь 14 настайгаасаа эрүүл мэнд болон бусад үзлэгт жил бүр хамрагдаж, 15-16 насандаа биеийн тамирын сорил өгдөг. Сорилтод хамрагдахын тулд 148 см-ээс дээш өндөртэй, 43 кг-аас дээш жинтэй байх ёстой. Ингээд 17 настайдаа дунд сургуулиа төгсөөд цэргийн албанд татагдаж, 30 нас хүртлээ алба хаадаг. Хэрвээ үргэлжлүүлэн их, дээд сургууль болон коллежид элсвэл алба хаах хугацааг нь хойшлуулдаг.

Өнөөдрийн байдлаар тухайн иргэн цэрэгт татагдахад ар гэрт нь үзүүлдэг урамшууллын хэмжээ маш бага болсон. Цэргийн алба хаагчийн нийгэмд эзлэх нэр хүнд их, нөгөө талаар цэрэгт явж үзээгүй бол олон нийтийн дарамт, шахалт ихтэй байдагтай холбоотойгоор тус улсын залуусын цэрэгт алба хаах сонирхол их. Мөн иргэд нь нийгмийн хамгааллын бодлогод орохын тулд зайлшгүй цэргийн аль нэг байгууллагад элссэн байх шаардлагатай юм.

ЭМЭГТЭЙЧҮҮД Ч ЭРЧҮҮДИЙН АДИЛ ЦЭРГИЙН АЛБЫГ ХААНА

Израиль Улсын хувьд 18 нас хүрсэн бүх хүн эрэгтэй, эмэгтэй гэж ялгалгүй цэргийн албыг заавал хаах ёстой. Харин тус улсын араб үндэстнүүд

тодорхой шалтгааны улмаас чөлөөлөгдсөн аж. Израилын Батлан хамгаалахын хуулийн дагуу тус улсын Зэвсэгт хүчин орон даяар цэрэг татлага болон



цэрэгт татагддаггүй. Зөвхөн өөрийн хүсэлтээр цэргийн алба хаах боломжтой. Эрэгтэйчүүдийн алба хаах нас нь 18-29 бөгөөд 32 сар буюу албан тушаалаас нь хамааран зарим тохиолдолд дөрвөн сар хүртэл сунгагдана. Эмэгтэйчүүдийнх 18-26 нас ба 24 сар буюу албан тушаалаас хамааран зарим тохиолдолд дөрвөн сар хүртэл сунгагдана.

Хэрвээ тухайн иргэн эмч мэргэжилтэй бол 30-34 нас хүртлээ алба хаах хугацаагаа хойшлуулж болно. Харин тус улсад цагаачилж амьдарч байгаа иргэд эрэгтэй, эмэгтэй гэлтгүй 27 наснаас эхлэн 20 сарын хугацаанд цэрэгт татагддаг. Сүүлийн жилийн судалгаагаар тус улсын нийт цэргийн насны залуусын 26 хувь нь цэргийн албанаас

дайчилгааг зохион байгуулдаг. Ингээд биеийн тамирын шалгуур үзүүлэлт болон эрүүл мэндээрээ хамгийн өндөр орноо авснаар нь эрэмбэлэх маягаар үндсэн таван мотобуудлагын болон инженер, сапёрын ангиудад хуваарилдаг. Дундаж оноотнууд нь артиллери, хуягт танк, хилийн цэргийн ангиудад хуваарилагддаг. Арай доогуур үнэлэгдсэн нь хангалт үйлчилгээ, ар тал, техникийн дэмжлэгийн ангиудад алба хаадаг аж.

Жирэмсэн эсвэл бага насны хүүхэдтэй, шашны шалтгаанаар цэргийн албанаас чөлөөлөгдөх боломжтой гэдгээ нотолсон эмэгтэйчүүдийг цэргийн албанаас чөлөөлдөг. Харин эрэгтэйчүүдийн хувьд зөвхөн эрүүл мэндийн шалтгаанаар чөлөөлөгдөх боломжтой.

16.5 НАСТАЙДАА ЦЭРГИЙН АЛБА ХААЖ БОЛНО

Сингапурт 18 нас хүрсэн эрэгтэй хүн бүр цэргийн алба хаах хуультай. Тус хууль нь анх 1967 онд Сингапурын Зэвсэгт хүчин байгуулагдахад батлагдаж байсан түүхтэй. Түүнээс хойш нэмэлт өөрчлөлт орсоор эдүгээ цэргийн албанаас гадна цагдаа, иргэний хамгаалалтын албанд иргэдийг татан оролцуулдаг болжээ. Цэрэг татлагын тухай хуулиар тус улсын иргэн болон байнгын оршин суух эрхтэй цагаач иргэд хоёр жилийн хугацаанд цэргийн албыг Сингапурын Зэвсэгт хүчин, Цагдаа эсвэл Иргэний хамгаалалтын албанд хаах боломжтой.

Тус улс нь 1967 онд тусгаар тогтнохдоо ердөө 1000 гаруй цэрэгтэй байсан учир тухайн үеийн улс төрчид эх орноо батлан хамгаалахын тулд ихээхэн хэмжээний цэргийн хүчийг бий болгох шаардлагатай гэж үзсэн. Нөгөөтэйгүүр 1960-аад оноос эхлэн Их Британи Улс Сингапурын зүүн эрэг дагуух Суэцын суваг орчмоос цэргүүдээ татаж эхэлсэнтэй холбогдуулж Засгийн газар улс орныг батлан хамгаалах хэрэгцээнд зориулж бүх нийтээрээ цэргийн алба хаах тухай хуулийг 1967 онд баталсан юм. Ингэхдээ Швейцарын цэрэг татлагын тогтолцоонд суурилсан хуулийг боловсруулж, 1949 оны 1 дүгээр сарын 1-нээс 6 дугаар сарын 30-ны хооронд төрсөн 9 мянга орчим залуусыг анх удаа цэрэгт татаж байжээ.

Эдүгээ цэрэгт татагдагч нь хоёр сарын хугацаанд цэргийн анхан шатны болон биеийн тамирын сургалтад хамрагддаг. Биеийн тамирын шалгалтад гар дээр суниах, 2.4 км гүйх зэрэг цэрэгжлийн нормативыг биелүүлдэг. Цэрэг татагдагчийн хувьд 18-40 насны хооронд байж болдог. Зарим тохиолдолд зөвхөн эрчүүдээр хязгаарлагдахгүй эмэгтэйчүүдийг тодорхой албан тушаалд цэрэгт татдаг. Тухайн иргэн 16.5 настайгаасаа хоёр жил дараалан заавал эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байх шаардлагатай. Ингээд 18 настайдаа эрүүл мэнд, бие бялдрынхаа түвшинг тогтоолгосноор аль салбарт алба хаавал илүү тохирохыг Цэргийн төв комиссоос зааж өгдөг байна. Мөн эцэг, эхийн зөвшөөрлөөр эрт цэргийн албанд элсүүлдэг. Бие бялдрын хөгжил, эрүүл мэндээрээ тэнцвэл 16,5 настайгаасаа эхлэн шууд алба хааж болдог.

Байнгын оршин суух эрхтэй цагаачдын хувьд эцэг, эх нь зөвшөөрсний үндсэн сайн дураар цэргийн албанд элсэх нь нээлттэй. Цагаач иргэдийн хувьд цэрэгт алба хаах сонирхол өндөр байдаг. Учир нь хугацаат цэргийн албыг бүрэн хаасан хүн тус улсын Иргэн харьяатын төвд Сингапурын иргэн болох өргөдөл өгөх эрх нээгддэг. Цэргийн алба хааж дууссан ч тухайн иргэн нь жил бүр дайчилгааны цэргийн сургалтад хамрагдаж байх ёстой аж.

Эх сурвалж: www.wikipedia.com

Хобби

Н.Хүдэрбат: ТУХАЙН ОРНЫ ХӨГЖЛИЙГ МӨНГӨН ДЭВСГЭРТЭЭС НЬ ХАРЖ БОЛДОГ



Бид энэ удаагийн "Хобби" буландаа ҮБХИС-ийн БХЭШХ-гийн Түүх судлалын төвийн дарга, дэд хурандаа Н.ХҮДЭРБАТЫГ урьж оролцууллаа.

Хэзээнээс эхэлж мөнгөн тэмдэгтүүд цуглуулж эхлэв? Анх сонирхлыг тань хэрхэн татсан бэ?

-Би 2013 онд Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад явагдаж буй НҮБ-ын энхийг сахиулах "UNMISS" ажиллагаанд Монгол Улсын Зэвсэгт хүчний гуравдугаар ээлжийн мотобуудлагын батальонд үүрэг гүйцэтгэсэн. Ажиллагааны газар оронд очоод өмнөх цэргийн багтай ээлж солилцох үеэр дэслэгч С.Түвшинбаатар гэдэг залуутай танилцсан юм. Тухайн үед тэр залуу надад Катар Улсын мөнгөн дэвсгэртийг дурсгал болгон өгсөн нь миний цуглуулгын хамгийн анхных буюу эхлэл байсан гэж хэлж болно. Тэр өдрөөс хойш мөнгөн тэмдэгт цуглуулах хоббитой болсон. Өмнөд Судан Улсад өнгөрүүлсэн жил орчмын хугацаанд 70 гаруй улсын мөнгөн дэвсгэртийг цуглуулсан. Цуглуулгаа баяжуулахын тулд бусад орны цэргүүдтэй харилцах шаардлагатай болсон тул англи хэл сурч эхэлсэн. Энэ маань ч үр өгөөжөө өгч монгол орныхоо мөнгөн дэвсгэртийг өөр улсынхтай солилцох журмаар цуглуулгаа арвижуулж эхэлсэн дээ.

Таны цуглуулгаас хамгийн үнэ цэнтэй нь ...

-Хамгийн үнэ цэнтэй нь Германы эзэнт гүрний үе буюу 1910 онд үйлдвэрлэгдсэн мөнгөн дэвсгэрт юм. Учир нь тус мөнгөн дэвсгэртийг надад байгаа хамгийн эртнийх гэж хэлж болно. Олж авсан түүх нь ч сонин. Манай сургуулийн Аюулгүй байдлын сургуулийн оюутан Д.Мөнх-Эрдэнэ гэдэг залуу илтгэл тавих талаар надаас зөвлөгөө авч байсан юм. Жилийн дараа тэр залуу надтай таараад Герман Улсад сургуульд сурахаар болсон талаараа хэлсэн. Тухайн үед баяр хүргээд л өнгөрсөн. Хэдэн сарын дараа гадаадаас дуудлага ирж байна. Гайхаад утсаа автал өнөөх Д.Мөнх-Эрдэнэ дүү маань надад зориулаад зах дээрээс хуучны мөнгөн тэмдэгт худалдаж авсан талаараа дуулгасан. Тэр үед их л сэтгэл хөдөлж байснаа санаж байна.

Та цуглуулгаа тоолж үзсэн үү? Хэдэн улсын мөнгөн дэвсгэрт таны цуглуулгад байгаа вэ?

-Миний тооцоогоор 170 улсын 300 орчим цаасан мөнгө бий. Дахиад 30 орчим орон үлдсэн. Ихэнх нь арлын улсуудын мөнгөн тэмдэгтүүд. Тэдгээрийг олж цуглуулна гэдэг тун амаргүй.

Мөнгөн дэвсгэрт юуг илэрхийлдэг вэ?

-Мөнгөн дэвсгэрт тухайн орны тусгаар тогтнолын баталгаа болохоос гадна хөгжлийн түвшинг тодоор харуулдаг. Барууны

өндөр хөгжилтэй орны мөнгөн дэвсгэртийг аль нэг буурай орныхтой харьцуулахад материал, нууцлалын хувьд маш их ялгаа харагддаг. Жишээ нь, Канад Улсын мөнгөн дэвсгэртийг базаад шидсэн ч нугалардаггүй. Тэр ч бүү хэл зарим орны мөнгөн дэвсгэртүүд шатдаггүй талаар ч цуглуулагчид ярьдаг.

Цуглуулгаа хэрхэн баяжуулдаг вэ?

-Миний хоббиг гэр бүл, найз нөхөд, ажлын хамтрагч нар маань бүгд мэддэг учир мөнгөн дэвсгэртүүд бэлэглэдэг. Тухай бүрт нь хэн, хэзээ, ямар цолтой байхдаа

хааны зургийг мөнгөн дэвсгэртдээ хүндэтгэн байршуулсан байдаг. Миний цуглуулгад тэдгээр цаасан мөнгөнүүд бий. Харин надад байгаа хамгийн содон цуглуулга бол Зимбабве Улсын нэг тэрбум долларын мөнгөн дэвсгэрт. Энэ бол эдийн засгийн уналтад орсон, мөнгөний үнэ цэн алдагдсан орныг батлах баримт. Тэгэхдээ 2016 оны 12 дугаар сард гүйлгээнээс хассан учир ашиглагдахаа больж, зүгээр л түүх болж үлдсэн. Харин одоо Зимбабве Улс бага тоотой мөнгөөр арилжаа хийдэг болсон.

Цаашид цуглуулгаа ямар байдлаар өргөжүүлэх вэ?

-Би өөрөө түүхч хүн учир зарим нэг ховордсон мөнгөн дэвсгэртийг олж авахаар хайж



алийг нь бэлэглэж байсан бэ гэдгийг нямбай гэгч нь бичээд хадгалчихдаг нь миний цуглуулгын нэг онцлог. Энэ нь хожим түүхэн баримт болж үлддэг гэдгээрээ сонирхолтой. Мөн гадаадын сургууль, зарим сургалт, дамжаа, цэргийн ажиллагаанд оролцохоор хилийн дээс алхаж буй найзууд, ах, эгч болон шавь нартаа тухайн орны мөнгөн тэмдэгтийг захидаг. Дээрээс нь, зоос, цаасан мөнгө цуглуулагчидтай холбоо тогтоож, улмаар өөрт байхгүй цуглуулгаа олж авдаг.

Цуглуулгынхаа хамгийн содноос сонирхуулахгүй юу?

-Миний содон цуглуулгуудын нэг бол Шотланд Улсын мөнгөн дэвсгэрт. Шотланд Улс Их Британы нэг хэсэг ч гэсэн өөрсдийн онцлогийг харуулсан тусдаа мөнгөн дэвсгэртэй. Үүнийг би Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад явагдаж буй НҮБ-ын энхийг сахиулах "UNMISS" ажиллагаанд Монгол Улсын Зэвсэгт хүчний наймдугаар ээлжийн мотобуудлагын батальонд үүрэг гүйцэтгэж байхдаа Английн инженерийн ротын нэг ахлагчаас бэлэг болгон авч байсан. Түүний аав нь шотланд хүн учраас өөрт нь энэ ховор цаасан мөнгө явж байж л дээ. Намайг энэ төрлийн хоббитой гэдгийг мэдээд надад өгсөн. Мөн Костарико Улсын мөнгөн тэмдэгт нь ил захидал шиг нэлэнхийдээ өнгөт том зурагтайгаар загварчлагдсан байдаг бол өмнө нь Английн колони орнууд байсан зарим улс одоо хүртэл Элизабет хатан

байгаа. Жишээ нь, Орос Улс Хаант засаглалаа халж түр Засгийн газрыг байгуулсан үе буюу 1917 онд ашиглагдаж байсан мөнгөн тэмдэгт дээр хас тэмдгийг оруулсан байдаг нь миний судалгааны ажилтай холбогддог. Дээрээс нь, Монгол оронд хэрэглэгдэж байсан мөнгөн дэвсгэртүүдийг цуглуулах талаар сүүлийн үед түлхүү анхаарч байна. Ямар ч цаасан мөнгө цуглуулагчийн мөрөөдөл бол "Данзангийн доллар"-ыг цуглуулгадаа нэмэх байдаг. Би ч мөн адил. Анх энэ доллар нийт 10.000 ширхэг хэвлэгдэж байсан ч хэдхэн жил ашиглагдаад устгалд орсон. Одоо маш ховордсон учир төдий чинээ үнэ цэнтэй. Зарим цуглуулагчид байдаг талаар сонсож байсан. Нэг ширхэг нь гэхэд хэдэн ерөө байрны үнэтэй тэнцдэг гэсэн яриа бий.

Өөр ямар цуглуулгатай вэ?

-Би зоосон мөнгөний цуглуулгатай. Ерөнхийдөө 100 гаруй улсын зоос бий. Мөн дээрээс нь номын цуглуулгатай. Ойролцоогоор 500 орчим ном миний номын санг эзэлдэг. Ихэвчлэн социализмын үед хэвлэгдэж байсан алтан үеийн зохиолчдын номууд зонхилдог. Жишээ нь "Манан будан", "Зүрхний хилэн", "Газар шороо" гэх зэрэг. Тэгэхдээ зохиолуудын хамгийн анхны хэвлэлтүүдийг цуглуулдаг онцлогтой. Сүүлийн үед цэргийн сэдэвтэй түүхийн номууд цуглуулж байна.

Дэд ахлагч Т.ИДЭР

Үндэсний бахархал,



Улаан-Одон сонины 1941 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн дугаар 2-т нийтлэгдсэн баримт: Партизаны ажиллагаа

Цэргийн төв клубийн хувцасны эрхлэгч, намын гишүүн партизан Цэнд-Аюуш нь хариуцсан ажилдаа нь онц сайн бөгөөд харьяат намын үүрээс өгсөн даалгаврыг ширхэг дараалан биелүүлдэг. Хамгийн үлгэртэй нөхөр мөн. Баримт нь нөхөр Цэнд-Аюуш намын үүрээс тус газрын албан хаагчид, байлдагчдын захиалгат сониныг зохих газраас гарсан цаг тухайд авчирч тараан олгуулж байхаар даалгаврыг өгснийг онц сайнаар гүйцэтгэж баймой. Энэ нь тэд нөхдийн улс төрийн мэдрэл /мэдлэг/ хүмүүжлийг хамгийн дээд шатнаа гаргахын тулд тэмцэж байхын үр мөн. Иймд бусад нөхдөөс намын гишүүн партизан Цэнд-Аюуш шиг ажиллахыг уриалмой. Даваа.

Батлан хамгаалахын төв архивын сан хөмрөгөөс

ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН МАГИСТР, ДОКТОРЫН ХӨТӨЛБӨРИЙН ХАВРЫН ЭЛСЭЛТИЙН ЗАР

ҮБХИС-ийн магистр, докторын хөтөлбөрт элсэлт авна.

Магистр, докторын сургалтад элсэхийг хүсэгчид 2021 оны 1 дүгээр сарын 2-17-ны өдрүүдэд цахимгаар бүртгүүлнэ үү.

Докторын хөтөлбөрт элсэхийг хүсэгч https://docs.google.com/.../1WVGf3wC1XC.../edit линкээр, магистрын хөтөлбөрт элсэхийг хүсэгч https://docs.google.com/.../1E1VDIajpAxeTxE0Bx0JeQr.../edit линкээр бүртгүүлнэ. Элсэлтийн шалгалт 2021 оны 1 дүгээр сарын 18-22-ны өдрүүдэд цахим хэлбэрээр явагдана.

Холбоо барих утас:

Магистрын хөтөлбөрт элсэгч: Утас: 86100101

Докторын хөтөлбөрт элсэгч: Утас: 99092890

АХИСАН ТҮВШНИЙ СУРГАЛТЫН АЛБА

ЭМГЭНЭЛ

БАЛДАНГИЙН ТҮВШИНБЯАР (1975-2021)

Бидний дотны нөхөр, Зэвсэгт хүчний шилдэг офицер, халамжит хань, хайрт аав, хурандаа Б.Түвшинбаяр өвчний улмаас 2021 оны 1 дүгээр сарын 7-ны өдөр хорвоогийн мөнх бусыг үзүүлж, бидэнд нөхөж баршгүй хүнд гарз тохиолоо.



Хурандаа Б.Түвшинбаяр нь 1975 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр Хэнтий аймгийн Баянхутаг суманд төрсөн. Тэрээр 1982-1990 онд Хэнтий аймгийн Бэрх сумын 10 жилийн дунд сургууль, 1990-1993 онд Дорнод аймгийн ХАА-н техникум, 1994-1998 онд Цэргийн их сургууль, 2003-2005 онд БХИС-ийн БХУА, 2018 онд ҮБХИС-ийн БХУА-ийн Стратегийн дамжааг тус тус амжилттай суралцан төгсөж, "Стратеги-оператив, цэргийн удирдлага" мэргэжил эзэмшсэн юм.

Хурандаа Б.Түвшинбаяр нь Зэвсэгт хүчинд 27 жил тасралтгүй ажилласны дотор Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийн ротын захирагч, батальоны захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга, албаны дарга, ангийн штабын даргын орлогч, оператив тасгийн дарга, ангийн захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга, бригадын захирагчийн орлогч, ЗХЖШ-ын Цэргийн тангуулын газарт мэргэжилтн, ҮБХИС-ийн ЦКС-ийн Ерөнхий цэргийн тэнхимийн ахлах багш, БХУА-ийн Цэргийн удирдлагын төвийн ахлах багш, төвийн даргаар тус тус томилогдон үр бүтээлтэй ажиллаж байв.

Тэрээр Монгол Улсын Зэвсэгт хүчний нэгтгэл, ангид алба хаах хугацаандаа хариуцсан анги, салбарынхаа бэлэн байдлыг хангах, сургалт бэлтгэлийг төлөвлөн зохион байгуулах, цэргийн албыг хэвшүүлэхэд өөрийн мэдлэг, ур чадвараа дайчлан ажиллаж чаддаг, манлайлагч, шинийг эрэлхийлэгч, чадварлаг удирдан зохион байгуулагч бөгөөд Зэвсэгт хүчин, Хуурай замын цэргийн хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулсан шилдэг офицер, "Иракийн эрх чөлөө" олон улсын цэргийн ажиллагаанд үүргээ амжилттай гүйцэтгэсэн шилдэг энхийг сахиулагч байсан юм.

Мөн Үндэсний батлан хамгаалахын их сургуульд ажиллах хугацаандаа Зэвсэгт хүчний залуу боловсон хүчинг бэлтгэх, тэдэнд цэргийн хэргийн мэдлэг олгох, мэргэжил эзэмшүүлэх болон Төрийн цэргийн байгууллагын удирдах албан тушаалд ажиллах чадвартай, шилдэг боловсон хүчинг бэлтгэх эрхэм үйлсэд өөрийн мэдлэг боловсрол, эрдэм ухаан, дадлага туршлагаа харамгүй хуваалцаж олон шавь бэлтгэн гаргасан тэргүүний багш, судлаач, сурган хүмүүжүүлэгч байлаа.

Түүний улс орныг батлан хамгаалах, Зэвсэгт хүчнийг хөгжүүлэн бэхжүүлэх болон энхийн үйлсэд оруулсан хичээл зүтгэл, хувь нэмрийг төр, засгаас өндрөөр үнэлж "Цэргийн хүндэт медаль", "Энхийн төлөө медаль", Дайчин алдар 1, 2, 3 дугаар зэргийн медаль, Эх орны төлөө 1, 2, 3 дугаар зэргийн хүндэт тэмдэг болон Төрийн цэргийн байгууллагуудын бусад медалиудаар шагнажээ.

Эрхэм Таны гэгээн дүр төрх, хүнлэг энэрэнгүй, ажилч хичээнгүй, шударга, зарчимч зан чанар гэр бүл, хамт олон, багш сурган хүмүүжүүлэгч, шавь, анд, найз нөхөд бидний зүрх сэтгэлд үүрд хоногшин үлдэх болно.

БХЯ, ЗХЖШ, ХЗЦК, ЦТГ, ҮБХИС, БХУА, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 016 ДУГААР НЭГТГЭЛ, 084, 327 ДУГААР АНГИ, МОНГОЛЫН ТАНКЧДЫН ХОЛБОО, ЦИС, БХУА-ИЙГ ХАМТ ТӨГСӨГЧИД, ХАМТ ОЛОН, ГЭР БҮЛ, ҮР ХҮҮХЭД, ТӨРӨЛ ТӨРӨГСӨД, АНД НАЙЗУУД НЬ

СОЁМБО СОНИН "Соёмбо" сонин 96 дахь жилдээ хэвлэгдэж байна. Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА, Д.НАЦАГДОРЖ

Дарга, ерөнхий редактор Хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ Эхийг "Соёмбо" сонины редактад бэлтгэж, "Соёмбо принтинг" хэвлэх үйлдвэрт хэвлүүлэв.

*Зар, рекламгыг хямд нийтэлнэ. *Зар, рекламгыг үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна. *Зохиогчийн үзэл болол сонины нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно. *Тус сонины мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс 10018 И-мэйл хаяг: Mil_newssoyombo@yahoo.com Утас: 70001029